



БНХАУ-д дулааны аргаар боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүн экспортлох

Монгол улсын бизнес эрхлэгчид, үйлдвэрлэгчдэд зориулсан
цогц гарын авлага

2020 он

Published by

giz Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH

Хэвлэлт

Хэвлэсэн

Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit (GIZ) GmbH

Хаяг

Бонн, Эшборн хот, ХБНГУ
Фредих-Элберт-Аллэ 32-36
Д-53113 Бонн, ХБНГУ
Утас +49 228 4460-0

Даг-Хаммарскуолд-Вег 1-5
Д-65760 Эшборн, ХБНГУ
Утас +49 6196 79-0

Цахим хаяг info@giz.de
Цахим хуудас www.giz.de

Төслийн нэр

Ази дахь бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааг дэмжих (SRECA)
ТаЮуан Дипломат Байр
14 Лиангмае Өмнөд Гудамж, Чаояанг Дүүрэг
10600 Бээжин, БНХАУ
Утас +86-10-8532-1857
Цахим хаяг sreca@giz.de
Цахим хуудас www.connecting-asia@giz.de / www.giz.de/en/worldwide/34101.html

Зохиогчид/Боловсруулсан

Т.Эрдэнэчулуун, Ц.Гантулга, Г.Энх-Амгалан, Ц.Батнаран, О.Амартүвшин
“Байгаль орчин, хөдөө аж ахуйн эдийн засгийн хүрээлэн” НҮТББ
Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, Зайсан
ХААИС-ийн ЭЗБС-ийн 202 тоот
Утас + 976 99092644, + 976 88005829
Цахим хаяг erdenechuluun.t@inrae.mn, gantulga.ts@inrae.mn
Цахим хуудас www.inrae.mn

Хянасан

С. Золзаяа, GIZ SRECA
Флориан Мисс, GIZ SRECA

Зураг

GIZ

Агуулгын хариуцлагаас татгалзах тухай

Энэхүү гарын авлагад зохиогчдын зүгээс илэрхийлсэн үзэл бодол болон саналд байгууллагын саналыг тусгаж, илэрхийлээгүй болно. ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны (BMZ) нэрийн өмнөөс/даалгавраар GIZ нь хэрэгжүүлэгч агентлагийн хувьд гарын авлагын агуулгыг хариуцна.

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	4
НЭГ. БНХАУ-Д ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХ ТУХАЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	5
1.1 БНХАУ-ЫН ҮХРИЙН МАХНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ, ОНЦЛОГ	7
1.1.1 ҮХРИЙН МАХНЫ ХЭРЭГЛЭЭ БА ҮНЭ	7
1.1.2 ҮХРИЙН МАХНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ БА НӨӨЦ.....	7
1.1.3 ЗОРИЛТОТ ЗАХ ЗЭЭЛИЙН ОНЦЛОГ	8
1.2 МОНГОЛ УЛСЫН ҮХРИЙН МАХ ҮЙЛДВЭРЛЭХ БОЛОМЖ, НӨХЦӨЛ БАЙДАЛ.....	9
1.2.1 ҮХРИЙН МАХНЫ ДОТООДЫН ХЭРЭГЛЭЭ БА ЭКСПОРТ	9
1.2.2 ҮХРИЙН МАХНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ БА НӨӨЦ.....	9
ХОЁР. БНХАУ-ЫН ЗАХ ЗЭЭЛД ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХ БОЛОМЖ, ЗОХИЦУУЛАЛТ	10
2.1 ОЛОН УЛСЫН ХУДАЛДААНЫ ЗОХИЦУУЛАЛТ	10
2.2 МОНГОЛ УЛСЫН ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЫН ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ 12	
2.3 БНХАУ-ЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ, НЭВТРЭХ ҮЙЛ ЯВЦ	14
2.4 БНХАУ-Д ЭКСПОРТЛОХ ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХОРИО ЦЭЭР.....	19
2.5 БҮЛГИЙН ШАЛГАХ ХУУДАС	22
ГУРАВ. БНХАУ-Д ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХ БЭЛТГЭЛ АЖИЛ	23
3.1 ГЭРЭЭ БАЙГУУЛАХ	23
3.1.1 ГЭРЭЭ БАЙГУУЛАХ БЭЛТГЭЛ АЖИЛ.....	23
3.1.2 ГЭРЭЭ БАЙГУУЛАХ.....	24
3.1.3 ГЭРЭЭНЭЭС ҮҮССЭН МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ	26
3.2 ТӨЛБӨР, ТООЦОО	26
3.3 ЭКСПОРТОД ГАРГАХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ САВ БАГЛАА БООДОЛ, ХАЯГ ШОШГО	27
3.3.1 САВ, БАГЛАА, БООДЛЫН СТАНДАРТ, ТУСГАЙ ШААРДЛАГА	27
3.3.2 МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНД ХЭРЭГЛЭДЭГ САВ, БАГЛАА, БООДЛЫН ТӨРЛҮҮД	28
3.3.3 ШОШГО, ХУДАЛДААНЫ ТЭМДЭГ, КОДЧИЛОЛ.....	28
3.4 ТЭЭВЭРЛЭЛТИЙН ГЭРЭЭ	29
3.5 БҮЛГИЙН ШАЛГАХ ХУУДАС	29
ДӨРӨВ. БНХАУ-Д ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХ ҮЙЛ ЯВЦ	30
4.1 ГЭРЧИЛГЭЭ, ЗӨВШӨӨРӨЛ	30

4.1.1 СТРАТЕГИЙН ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХ ЗӨВШӨӨРӨЛ	30
4.1.2 ДОТООДЫН МАЛ ЭМНЭЛГИЙН ГЭРЧИЛГЭЭ	31
4.1.3 БОДЛОГЫН ГЭРЭЭ	32
4.1.4 ТОХИРЛЫН ГЭРЧИЛГЭЭ	34
4.1.5 ГАРАЛ ҮҮСЛИЙН ГЭРЧИЛГЭЭ	35
4.1.6 ОЛОН УЛСЫН МАЛ ЭМНЭЛГИЙН ГЭРЧИЛГЭЭ	35
4.1.7 МАЛ ЭМНЭЛЭГ, АРИУН ЦЭВРИЙН ГЭРЧИЛГЭЭ	36
4.2 ТЭЭВЭРЛЭЛТ	37
4.3 ГААЛЬТАЙ ХОЛБООТОЙ ПРОЦЕСС	37
4.3.1 ЭКСПОРТЫН ГААЛИЙН ПРОЦЕСС	37
4.3.2 ИМПОРТЛОГЧИЙН ГААЛИЙН ПРОЦЕСС	39
4.4 БҮЛГИЙН ШАЛГАХ ХУУДАС	40
ТАВ. БНХАУ-Д ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН	
БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХ КОМПАНИУДАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ	41
ЗУРГАА. БНХАУ-Д ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН	
БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХОД ШААРДЛАГАТАЙ БАРИМТ БИЧИГ	44
6.1 МОНГОЛЫН ТАЛААС ШААРДЛАГАТАЙ БАРИМТ БИЧГҮҮДИЙН ЖАГСААЛТ	44
6.2 БНХАУ-ЫН ТАЛААС ШААРДЛАГАТАЙ БАРИМТ БИЧГҮҮДИЙН ЖАГСААЛТ	44
ДОЛОО. БНХАУ-Д ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН	
БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХОД ОРОЛЦДОГ БАЙГУУЛЛАГУУД	45
НАЙМ. БНХАУ-ЫН ЗАХ ЗЭЭЛД ХИЙХ ҮХРИЙН МАХНЫ ЭКСПОРТЫН ПРОГНОЗ	47
ЕС. ХАВСРАЛТ / ЦАХИМ ХУУДАСНЫ ЛИНК	48

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

БТКУС	Барааг Тодорхойлох, Кодлох Уялдуулсан Систем
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ГЕГ	Гаалийн Ерөнхий Газар
ГҮС	Гарал Үүслийн Систем
ДДД	Дахин Давтагдашгүй Дугаар
ДНБ	Дотоодын Нийт Бүтээгдэхүүн
ДГБ	Дэлхийн Гаалийн Байгууллага
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ММХ	Монголын Махны Холбоо
МХЕГ	Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
МҮХАҮТ	Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим
МЭЕГ	Мал Эмнэлгийн Ерөнхий Газар
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОУХТ	Олон Улсын Худалдааны Төв
СХЗГ	Стандарт, Хэмжил Зүйн Газар
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ХААГ	Хөдөө Аж Ахуйн Газар
ХХААХҮЯ	Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам
ХХБ	Худалдаа, Хөгжлийн Банк
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани
ЧХШХЦЕГ	Чанарын Хяналт Шалгалт, Хорио Цээрийн Ерөнхий Газар
CNCA	Certification and Accreditation Administration of China
CNIPA	China National Intellectual Property Administration
DC	Documentary Collections
GACC	General Administration Customs of China
LC	Letter of Credit
NHCC	National Health Commission of China
SAC	Standardization Administration of China
SAMR	State Administration for Market Regulation

НЭГ. БНХАУ-Д ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХ ТУХАЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

БНХАУ-ын эдийн засгийн төлөв: БНХАУ-ын эдийн засаг, гадаад хамтын ажиллагаа, худалдаа жил бүр өсөн нэмэгдэж байна. БНХАУ-ын ДНБ 2019 онд 11.4 их наяд америк долларт¹ хүрч, эдийн засаг нь өнгөрсөн он (2018)-той харьцуулахад 6.1 хувиар, сүүлийн 10 жилийн байдлаар жилд дунджаар 7.8 хувиар өссөн. Хэдийгээр тус улсын эдийн засаг жил бүр өсөх хандлагатай байгаа хэдий ч эдийн засгийн өсөлтийн хурд буурах хандлагатай байна. Өөрөөр хэлбэл, 2010 онд эдийн засгийн өсөлт 10.6 хувь байсан бол 2019 онд 6.1 хувь болтол буурсан байна. Цаашид тус улс эдийн засгийн өсөлт буурах төлөвтэй байгаа ба 2021 он гэхэд 5.8 хувь хүртэл буурах хандлагатай байна (Дэлхийн банк, 2018²).

Хэдийгээр БНХАУ-ын эдийн засгийн өсөлт цаашид буурах хандлагатай байгаа боловч, дэлхийн эдийн засгийн 21.9 хувийг БНХАУ-ын эдийн засаг бүрдүүлж байгаа нь дэлхийн тавцанд тухайн улсын эдийн засаг, гадаад харилцаа, хамтын ажиллагаа чухал байр суурь эзэлж байгааг илтгэж байна (Дэлхийн банк, 2018²).

Монгол Улсын БНХАУ-тай хийсэн гадаад худалдаа: 2019 оны байдлаар манай улс БНХАУ-тай 6.7 тэрбум америк долларын экспортын, 2 тэрбум америк долларын импортын худалдаа хийж, хоёр орны гадаад худалдааны нийт эргэлт 8.7 тэрбум америк долларт хүрсэн байна. 2019 оны худалдааны нийт эргэлтийг 2018 онтой харьцуулахад 3.9 хувиар, сүүлийн 5 жилд дунджаар 13.5 хувиар өссөн байна. Энэ нь хоёр орны гадаад хамтын ажиллагаа, худалдаа өргөжин тэлж байгааг харуулах нэг чухал үзүүлэлт болж байна (МУ-ын Гаалийн Ерөнхий Газар, 2019).

БНХАУ-ын зах зээлд экспортлох дулааны аргаар боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүнийг БТКУС-д үндэслэн тодорхойлох нь: БНХАУ-ын зах зээлд экспортлох бүтээгдэхүүний тарифын болон тарифын бус зохицуулалт, гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг тодорхойлох, худалдааны гэрээ хийх, гаалийн бүрдүүлэлт хийх зэрэг маш олон үйл ажиллагаанд тухайн барааг "Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем (БТКУС)"-д үндэслэсэн БНХАУ-ын тарифын кодын дагуу тодорхойлох нь чухал.

БТКУС-ийг анх 1983 онд дэлхийн гаалийн байгууллага (ДГБ)-аас боловсруулан гаргасан бөгөөд өнөөдрийн байдлаар 200 гаруй улс орон гаалийн тарифын жагсаалт батлах болон гадаад худалдааны статистик гаргахад ашиглаж байна. БТКУС-ийн тухай олон улсын конвенцод Монгол Улс 1991 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр нэгдэн орж, 1993 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн бол БНХАУ 1992 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн байна.

Олон улсын худалдааны чиг хандлага, байгаль орчин, нийгмийн асуудлууд, зах зээлд шинээр нэвтрүүлсэн бүтээгдэхүүн, дэвшилтэт технологи зэрэг олон хүчин зүйлсээс хамааран 5-6 жил тутам БТКУС-д нэмэлт өөрчлөлт оруулдаг бөгөөд БНХАУ-д хамгийн сүүлийн нэмэлт өөрчлөлт оруулсан хувилбар буюу Уялдуулсан Систем 2017 хүчин төгөлдөр мөрдөгдөж байна (БНХАУ-ын ГЕГ, <http://english.customs.gov.cn/>). БНХАУ-ын гаалийн байгууллага 2018 оны 8 дугаар сараас эхлэн 13 оронтой ангиллын код ашиглах болсон бөгөөд, эхний 6 орон нь БТКУС-ийн код, дараах 2 орон нь тарифын ангилал

¹ 2010 оны буюу зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ үндэслэн эдийн засгийн өсөлтийг тайлбарлав.

² WorldBank. (Dec, 2019). "China Economic Update - December 2019". Retrieved from worldbank.org: <https://www.worldbank.org/en/country/china/publication/china-economic-update-december-2019>

тодорхойлох үндэсний задаргаа, 9,10 дахь орон нь гаалийн хяналт шалгалттай холбоотой код, 11-13 дахь орон нь хорио цээрийн хяналттай холбоотой код байна (<http://www.transcustoms.com/HScode/>).

Монгол Улсаас БНХАУ-д экспортлох үхрийн мах, махан бүтээгдэхүүнийг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

- 0201 кодтой үхрийн шинэ эсвэл хөргөсөн мах,
- 0202 кодтой үхрийн хөлдүү мах,
- 1602 кодтой **мах**, дайвар эсвэл цусаар хийж бэлтгэсэн эсвэл нөөшилсөн бусад бүтээгдэхүүнийг тодорхойлсон³.

³ Өмнө хийгдсэн судалгааны ажлуудын үр дүн болон ГЕГ-ын Монгол Улсаас БНХАУ-тай хийсэн гадаад худалдааны статистик мэдээ (2013-2018 он)-нд үндэслэн тодорхойлсон.

1.1 БНХАУ-ЫН ҮХРИЙН МАХНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ, ОНЦЛОГ

1.1.1 ҮХРИЙН МАХНЫ ХЭРЭГЛЭЭ БА ҮНЭ

БНХАУ-ын үхрийн махны нийт хэрэглээ жил ирэх тусам өсөх хандлагатай байна. БНХАУ-ын үхрийн махны нийт хэрэглээ 2019 онд 7.7 сая тонн болж, өнгөрсөн онтой харьцуулахад 0.4 хувиар, 2010 онтой харьцуулахад 23.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



БНХАУ-ын дотоодын зах зээлд нэг кг үхрийн махны үнэ дунджаар 65.2 юань буюу 25800 төгрөгөөр худалдаалж байна (Монголбанкны 2020 оны 01-р сарын 12-ны өдрийн албан ёсны ханшаар).

Зураг 1. БНХАУ-ын үхрийн махны хэрэглээ ба үнэ

Эх сурвалж: www.oecd.org, www.intracen.org, www.knoema.com, www.chnci.com

1.1.2 ҮХРИЙН МАХНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ БА НӨӨЦ

БНХАУ-ын үхрийн махны үйлдвэрлэл 2019 онд 6.36 сая тонн болж, өнгөрсөн онтой харьцуулахад 0.4 сая тонноор, сүүлийн 5 жилийн байдлаар жилд дунджаар 1.5 хувиар буурсан байна. Мөн 2019 оны байдлаар үхрийн махны нийт үйлдвэрлэлийн 98.3 хувийг дотоодын зах зээлд, үлдсэн хувийг гадаад зах зээлд нийлүүлсэн байна.

НӨӨЦ**ҮХРИЙН МАХНЫ НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, ТҮҮНИЙ БҮТЭЦ**

2018 онд үхрийн тоо толгой 90.0 сая толгой болсон.

2007-2018 оны хооронд үхрийн тоо толгой жилд дунджаар 1.3 хувиар буурсан.

Үхрийн махны үйлдвэрлэл, сая тонн



**ҮХРИЙН МАХНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ
БУУРАХ ХАНДЛАГАТАЙ БАЙНА**

НИЙЛҮҮЛЭЛТ

Category	2014	2015	2016	2017	2018	2019
ДОТООДЫН ЗАХ ЗЭЭЛД:	89.4%	92.4%	89.7%	95.6%	98.0%	98.3%
ГАДААД ЗАХ ЗЭЭЛД:	10.6%	7.6%	10.3%	4.4%	2.0%	1.7%
НИЙТ:	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%


Зураг 2. БНХАУ-ын үхрийн махны үйлдвэрлэл ба нөөц

Эх сурвалж: www.intracen.org, www.knoema.com, www.chnci.com

1.1.3 ЗОРИЛТОТ ЗАХ ЗЭЭЛИЙН ОНЦЛОГ

- Хүн амын амьжиргааны төвшин дээшилж буйтай холбоотой дотоодын зах зээл дэх махны хэрэглээ өсч байна.
- БНХАУ-ын махны салбарт гахайн мялзан өвчин гарсантай холбоотойгоор үхрийн махны хэрэглээнд дараах өөрчлөлт гарч байна:
 - Махны хэрэглээний бүтэц (махны төрөл) өөрчлөгдөж байна. Өөрөөр хэлбэл, гахайн махны хэрэглээнээс үхрийн махны хэрэглээнд шилжих хандлагатай болсон.
 - Гахайн махны хэрэглээ 2014 оноос тогтмол буурч байгаа бөгөөд 2018 онд 55.2 сая тонн гахайн махны хэрэглээтэй байгаа нь 2014 оноос 3.5 сая тн-оор буурсан үзүүлэлттэй байна. Харин үхрийн махны хувьд 2014 онтой харьцуулахад 2018 онд 1.2 сая. тн-оор хэрэглээ нь өссөн байна.
 - 2018 онд БНХАУ-ын нийт махны импортын бүтцийг авч үзэхэд үхрийн махны импорт 44.06 орчим хувийг эзэлж байна. Мөн тус онд үхрийн махны импортыг өмнөх онтой харьцуулахад 55.76 хувиар өссөн байна (БНХАУ-ын аж үйлдвэрийн тэнхим, 2019⁴).

⁴ China chamber of commerce for I/E of foodstuffs. (2020, 3 17). China Food Import Report 2019. Retrieved from CHEMLINKED: <https://food.chemlinked.com/report/china-food-import-report-2019>



Зураг 3. БНХАУ-ын махны хэрэглээний бүтэц, сая. тн

Эх сурвалж: <https://oec.world/>

1.2 МОНГОЛ УЛСЫН ҮХРИЙН МАХ ҮЙЛДВЭРЛЭХ БОЛОМЖ, НӨХЦӨЛ БАЙДАЛ

1.2.1 ҮХРИЙН МАХНЫ ДОТООДЫН ХЭРЭГЛЭЭ БА ЭКСПОРТ

2018 онд нийт 126.6 мянган тонн үхрийн мах бэлтгэсэн ба үүний 99.2 хувийг дотоодын зах зээлд, үлдсэн 0.8 хувийг гадаад зах зээлд нэг кг үхрийн махыг дунджаар 3.01 америк долларын үнэтэйгээр нийлүүлсэн байна. Манай улсын үхрийн махны экспорт өнгөрсөн хугацаа (2013-2018)-нд жилд дунджаар 1.2 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа ба цаашид өсөх хандлагатай байна.

МАХНЫ НИЙЛҮҮЛЭЛТ	НИЙТ ХЭРЭГЛЭЭ	НЭГ ХҮНД НОГДОХ ХЭРЭГЛЭЭ
<p>НИЙТ ҮЙЛДВЭРЛЭСЭН МАХ:</p> <ul style="list-style-type: none"> 126.6 мян.тн (ҮСХ, 2018) <p>Дотоодын зах зээлд нийлүүлсэн мах:</p> <ul style="list-style-type: none"> Дотоодод үйлдвэрлэсэн нийт махны 99.2 хувийг буюу 125.4 мян.тн үхрийн махыг дотоодын зах зээлд, Жилд дунджаар 18.9 хувиар өссөн (2013-2018). <p>Гадаад зах зээлд нийлүүлсэн:</p> <ul style="list-style-type: none"> Дотоодод үйлдвэрлэсэн нийт махны 0.8 хувийг буюу 1.05 мян.тн үхрийн махыг гадаад зах зээлд, Жилд дунджаар 1.2 дахин өссөн (2013-2018). 	<p>ДОТООДЫН НИЙТ ХЭРЭГЛЭЭ:</p> <ul style="list-style-type: none"> 125.4 мян.тн үхрийн махыг дотоодын нийт хэрэглээнд зарцуулсан, Цаашид өсөх хандлагатай байна. <p>ЭКСПОРТ:</p> <ul style="list-style-type: none"> 1.05 мян.тн үхрийн махыг БНХАУ, ОХУ, Казахстан зэрэг улсад нийлүүлсэн, Нэг кг үхрийн махны дундаж үнэ 3.01 америк доллар буюу 8294 төгрөгөөр (2020 оны 2 сарын 13-ны өдрийн ханшаар), Цаашид өсөх хандлагатай байна. 	<p>ДОТООДЫН ХЭРЭГЛЭГЧ:</p> <ul style="list-style-type: none"> Монгол Улсын хүн амын тоо жил ирэх тусам өсч, 2018 оны байдлаар 3.2 сая хүнд хүрсэн байна. <p>НЭГ ХҮНД НОГДОХ ХЭРЭГЛЭЭ</p> <ul style="list-style-type: none"> Үхрийн махны нэг хүнд ногдох жилийн хэрэглээ 38.7 кг байна.

Эх сурвалж: МУ-ын ХХААХҮЯ, ҮСХ болон ГЕГ-ын статистик мэдээ, түүнд үндэслэн тооцсон үр дүн

1.2.2 ҮХРИЙН МАХНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ БА НӨӨЦ

Манай улсын үхэр сүргийн тоо жил ирэх тусам өсөх хандлагатай байгаа ба 2018 оны байдлаар 1002.2 мянган толгой үхэр хэрэглээнд зарцуулж, 126.6 мянган тонн үхрийн мах

бэлтгэсэн ба үүний 4.4 хувийг буюу 5.5 мянган тонн үхрийн махыг үйлдвэрийн аргаар бэлтгэсэн байна.

НӨӨЦ	ҮЙЛДВЭРЛЭЛ			
<p>НИЙТ ҮХРИЙН ТОО:</p> <ul style="list-style-type: none"> • 4.4 сая толгойд хүрч, • Жилд дунджаар 1.9 хувиар өссөн (2000-2018) ба, • Цаашид өсөх хандлагатай байна (ҮСХ, 2018). <p>ҮХРИЙН МАХНЫ НӨӨЦ:</p> <ul style="list-style-type: none"> • Бэлчээрийн даацад суурилсан үхрийн тоонд үндэслэн тооцсон махны нөөц 279.8 мян.тн байна (ҮСХ, 2018). • Цаашид өсөх хандлагатай байна. 	<p>ХЭРЭГЛЭЭНД ҮХРИЙН ТОО:</p> <ul style="list-style-type: none"> • Нийт үхэр сүргийн 22.9 хувийг буюу 1002.2 мянган толгой үхрийг хэрэглээнд зарцуулсан байна (ҮСХ, 2018), • 2010-2018 оны хооронд жилд дунджаар нийт үхэр сүргийн 18 орчим хувийг хэрэглээнд зарцуулсан ба, • Цаашид өсөх хандлагатай байна. <p>ҮХРИЙН МАХ БЭЛТГЭЛ:</p> <ul style="list-style-type: none"> • 126.6 мян.тн үхрийн мах бэлтгэсэн (ҮСХ, 2018) ба, • Жилд дунджаар 17 хувиар өссөн (2013-2018), • Цаашид өсөх хандлагатай байна. 	<p>ЗАРЦУУЛСАН</p>	<p>ҮЙЛДВЭРИЙН БЭЛТГЭСЭН МАХ:</p> <ul style="list-style-type: none"> • Нийт бэлтгэсэн махны 4.4 хувийг буюу 5.5 мян.тн үхрийн махыг үйлдвэрийн аргаар бэлтгэсэн байна (ҮСХ, 2018), • Жилд дунджаар 2.3 хувиар өсч байна (2014-2018) ба, • Цаашид өсөх хандлагатай байна. <p>МАЛ ТӨХӨӨРӨХ ҮЙЛДВЭР:</p> <ul style="list-style-type: none"> • Монгол Улсад мал төхөөрөх нийт 88 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна (МХЕГ, 2019), • Хүчин чадлын хувьд жилд 9.7 сая толгой бог мал, 1.9 сая толгой бод мал төхөөрөх боломжтой байна (МХЕГ, 2019). 	<p>АРГААР</p>

Эх сурвалж: МУ-ын ХХААХҮЯ, ҮСХ болон ГЕГ-ын статистик мэдээ, түүнд үндэслэн тооцсон үр дүн

ХОЁР. БНХАУ-ЫН ЗАХ ЗЭЭЛД ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХ БОЛОМЖ, ЗОХИЦУУЛАЛТ

Монгол улс болон БНХАУ хоорондын гадаад худалдаа жил ирэх бүр өсөн нэмэгдэж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд ХАА-н бүтээгдэхүүн (мах)-ний экспорт хурдацтай өсөж байна. Түүнчлэн 2 улсын төрийн удирдах байгууллагуудын хамтын ажиллагаа улам бүр нягтарч, ялангуяа махны экспортыг дэмжсэн бодлогын баримт бичгүүд, гэрээ, хэлэлцээр, протоколууд үйлдсэн байгаа нь махны экспортыг нэмэгдүүлэх үндэс болж байна.

2.1 ОЛОН УЛСЫН ХУДАЛДААНЫ ЗОХИЦУУЛАЛТ

Монгол Улс 1991 онд Дэлхийн Гаалийн Байгууллага (ДГБ), 1997 онд Дэлхийн Худалдааны Байгууллага (ДХБ)-ын гишүүнээр элсэн орсноор эдгээр байгууллагын чиглэл, зарчмыг үндэсний хууль тогтоомжид уялдуулах, худалдааг хөнгөвчлөх талаарх олон арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

ДГБ-ын 1999 оны Шинэчлэн найруулсан Киотогийн конвенц болон уг конвенцын зааварт гаалийн горимыг хялбаршуулах, уялдуулахтай холбоотой үйл ажиллагааг стандартчилж, дэлгэрүүлж өгсөн ба Монгол Улс уг конвенцод 2006 онд нэгдэн орсноор “Гаалийн тухай” хууль, “Гаалийн тариф, гаалийн татварын тухай” хуулийн шинэчилсэн найруулгыг 2008 онд батлан гаргаж, түүнтэй уялдуулан холбогдох дүрэм, журам, зааврыг шинэчлэн үйл ажиллагаандаа мөрдөж байна.

ДГБ болон ДХБ-аас гаргасан зарим бодлогын баримт бичигт нэгдэн орсон огноог дараах хүснэгтэд харьцуулан үзүүлэв.

Хүснэгт 1. ДГБ, ДХБ-аас гаргасан зарим гэрээ, хэлэлцээр, бодлогын гол баримт бичигт Монгол Улс болон БНХАУ нэгдэн орсон байдал*

№	Баримт бичгийн нэр	Монгол Улс	БНХАУ
---	--------------------	------------	-------

1	ДГБ-ын Гаалийн хамтын ажиллагааны зөвлөл байгуулах тухай Конвенц (ДГБ байгуулах тухай Конвенц)	1991	1983
2	ДГБ-ын Барааг Тодорхойлох, Кодлох Уялдуулсан Системийн конвенц	1993	1993
3	ДГБ-ын Гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай олон улсын Конвенц	2006	2001
4	ДГБ-ын Дэлхийн худалдааг аюулгүй байлгах хөнгөвчлөх багц стандарт	2005	2005
5	Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Хэлэлцээр (ДХБ-ын Хэлэлцээр, Марракешийн Хэлэлцээр)	1997	2011
6	1994 оны ТХЕХ-ийн VII зүйлийг хэрэгжүүлэх тухай Хэлэлцээр (ДХБ-ын Үнэлгээний Хэлэлцээр)	1997	2011
7	ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр	2016	2015

Тайлбар: *гэрээ хүчин төгөлдөр болсон огноо

Эх сурвалж: Д.Цэндсүрэн (Ph.D), Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын гадаад худалдааны бодлого, гаалийн үйл ажиллагааг уялдуулж, гадаад худалдааг хөнгөвчлөх боломж, 2019



Зураг 4. ДХБ-ын худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн нэгдүгээр хэсэг: Монгол Улсын үүрэг амлалт

Эх сурвалж: ДХБ-ын 2014 оны 7 дугаар сарын 29-ний WT/PCTF/N/MNG/1, 2018 оны 2 дугаар сарын 22-ны G/TFA/N/MNG/1 тоот албан бичиг

Махны эрүүл ахуй, аюулгүй байдлын талаар олон улсад мөрдөж буй стандартуудыг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 2. Махны эрүүл ахуй, аюулгүй байдлын талаар олон улсад мөрдөж буй стандарт

№	Баримт бичгийн нэр	Индекс, код	Монголын үндэсний стандартаар батлагдсан байдал
1	Махны эрүүл ахуйн дадлын дүрэм	CAC/RCP 58; 2005	MNS CAC RCP 58:2013
2	Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо	ISO/MNS 22000	MNS ISO/IEC 22000:2007
3	Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим	CAC/MNS 1- 2003	MNS CAC/ RCP 1 :2003

4	Хүнсний импорт, экспортын хяналт, баталгаажуулалтын тогтолцоог хэрэгжүүлэх, үнэлэх болон итгэмжлэх ерөнхий зарчим	CAC/GL 26- 1997	MNS CAC/ GL 26- 2006
5	Хүнсний бүтээгдэхүүн дэх хорт болон бохирдуулагч бодисын ерөнхий стандарт	CAC/MNS 193:2007	MNS CAC 193:2007
6	Хүнсний бүтээгдэхүүн дэх малын эмийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ	CAC/MNS/ MRL 2:2009	MNS CAC MRL 2:2009
7	Хүнс, малын тэжээлийн гарал үүсэл – ерөнхий 7 зарчим ба төлөвлөх, хэрэгжүүлэх тогтолцоонд тавих үндсэн шаардлага	ISO 22005	
8	Хүнсний аюулгүй байдлын угтвар нөхцөлийн хөтөлбөр - Хэсэг 1. Хүнсний үйлдвэр	ISO/TS 22002-1:2009	
9	Хүнсний аюулгүй байдлын угтвар нөхцөлийн хөтөлбөр - Хэсэг 2. Хүнсний хангамж	SO/TS 22002-2:2013	
10	Хүнсний аюулгүй байдлын угтвар нөхцөлийн хөтөлбөр - Хэсэг 3. Фермерийн аж ахуй	ISO/TS 22002-3:2011	
11	Хүнсний аюулгүй байдлын угтвар нөхцөлийн хөтөлбөр - Хэсэг 4. Хүнсний савлагаа	ISO/TS 22002-4:2013	
12	Хүнсний аюулгүй байдлын угтвар нөхцөлийн хөтөлбөр - Хэсэг 5. Тээвэрлэлт, хадгалалт	ISO/NP TS 22002-5:	
13	Хүнсний аюулгүй байдлын угтвар нөхцөлийн хөтөлбөр - Хэсэг 6. Малыг тэжээлийн ба малын гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл	ISO/TS 22002-6:2016	

Эх сурвалж: МУ-ын СХЗГ

2.2 МОНГОЛ УЛСЫН ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЫН ТАЛААР БАРИМТАЛЖ БҮЙ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ

Үхрийн мах үйлдвэрлэж, БНХАУ-д экспортлохтой холбоотой үйл ажиллагаанд хамаарах “Мал, амьтны эрүүл мэндийн тухай” хууль, “Хүнсний тухай” хууль, “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай” хууль, “Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай” хууль, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, Мах, сүүний анхдугаар аян, Мах хөтөлбөр, Монгол мал үндэсний хөтөлбөр, Монгол Экспорт хөтөлбөр зэрэг Монгол улсын хуулиуд, үндэсний хөтөлбөр, бодлогууд болон 2 улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны чиглэлээр хийсэн засгийн газар, холбогдох байгууллагуудын гэрээ, хэлэлцээр, протокол, санамж бичиг зэрэг бичиг баримтуудаар зохицуулагдаж байна.

Хүснэгт 3. Монгол Улсад махны экспортын талаар мөрдөгдөж буй хууль эрх зүйн баримт бичиг

Хууль, эрхзүйн актууд	Төрийн бодлого, хөтөлбөр	Гэрээ, протокол	Дүрэм, журам
“Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай” хууль (2002.11.28)	“Монгол мал” үндэсний хөтөлбөр (2010 оны УИХ-ын 23-р тогтоол)	Хүнсний аюулгүй байдлын экспорт-импортын хамтын ажиллагааны хэлэлцээр, 2009 он	Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд экспорт, импортын гэрчилгээ олгох журам ((МУ-ын Засгийн газрын 2003 оны 173 дугаар тогтоол)
“Хүнсний тухай” хууль (2012.12.20) 6.7 дахь зүйл заалт 18.1 дэх зүйл заалт	“Мах” хөтөлбөр (2015 оны УИХ-ын 41-р тогтоол) 2.2 дахь заалт	Монгол Улсаас БНХАУ-д Дулааны аргаар боловсруулсан үхэр, хонь, ямааны мах, махан бүтээгдэхүүнийг экспортлох, импортлох үеийн хяналт, шалгалт, хорио цээр, мал эмнэлэг ариун цэврийн нөхцөл (2011.10.27)	Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хяналт, шалгалт хийх журам (МУ-ын Засгийн газрын 2003 оны 173 дугаар тогтоол)
“Хүнсний аюулгүй байдлын тухай” хууль (2012.12.20)	Мах, сүүний анхдугаар аян (Засгийн газрын 2016 оны 212 дугаар тогтоол)	Хил, гаалийн эрүүл ахуй, хорио цээрийн чиглэлд хамтран ажиллах Монгол улс, БНХАУ хоорондын хамтын ажиллагааны гэрээ, 2016	Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам (МУ-ын Засгийн Газрын 2019 оны 329 дүгээр тогтоол)
“Мал, амьтны эрүүл мэндийн тухай” хууль (2017.12.08)	“Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2018 оны 12 дугаар тогтоол “Монгол Экспорт” хөтөлбөр (2018 оны МУ-ын Засгийн Газрын 278-р тогтоол)	Монгол Улсын МХЕГ болон БНХАУ-ын Чанарын хяналт шалгалт, хорио цээрийн ерөнхий газар хооронд Монгол Улсаас БНХАУ-д экспортлох үхрийн махны хяналт шалгалт, хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн нөхцөлийн тухай протокол (2016.08.29)	Стратегийн хүнсний бүтээгдэхүүн экспортлох, импортлох нэр, төрөл тоо, хэмжээг тогтоох тухай ХХААХҮЯ-ны сайдын тушаал Гэрчилгээ, мэдэгдэл олгох бичиг баримтыг хүлээн авах, хариу өгөх журам (МХЕГ даргын 2019 оны 05 сарын 27 А/81 тушаал)

Хүснэгт 4. Махны үйлдвэрт мөрдөгдөж буй үндэсний стандарт, эрх зүйн баримт бичиг

№	Эрх зүйн баримт бичгийн нэр	Код, индекс
1	Хүнсний үйлдвэрлэл, эрүүл ахуйн зохистой дадлыг үндэсний хэмжээнд нэвтрүүлэх зөвлөмж	МХЕГ-ын даргын 2014 оны 156-р тушаал
2	Мал төхөөрөх үйлдвэр. Аюулын дүн шинжилгээ ба эгзгийг хянах цэгийн тогтолцоо (НАССР)-ны загвар стандарт	MNS 5998:2009
3	Мах, махан бүтээгдэхүүн. “Үхрийн хэсэглэж ангилсан мах” техникийн шаардлага	MNS 2456:2009
4	Чанаж боловсруулсан мах, Техникийн ерөнхий шаардлага	MNS 6790:2019
5	Хүнсний бүтээгдэхүүн дэх хүнд металлын үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ	MNS 4504:2008
6	Хүнсний бүтээгдэхүүн дэх пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ	MNS 5868:2008
7	Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хүнсний сүлжээнээс татан авах журам	ЗГ-ын 2013 оны 172-р тогтоол
8	Хүнсний бүтээгдэхүүн дэх бичил биетний аюулгүй байдал болон эрүүл ахуйн шалгуур үзүүлэлтийн зөвшөөрөгдөх хэмжээ	MNS 6308:2012
9	Эм, био-бэлдмэлийн үлдэгдэл, мг/кг	MNS CAC MRL 2:2017

Эх сурвалж: МУ-ын СХЗГ

Хүснэгт 5. Мах, махан бүтээгдэхүүнийг хүлээн авахад мөрдөгдөж буй стандарт

1	Мах, махан бүтээгдэхүүнийг шалгаж хүлээн авах ба сорьц авах, мэдрэхүйн эрхтнээр үнэлгээ өгөх журам	MNS 2551:89
2	Микробиологи, мах, махан бүтээгдэхүүн. Дээж авах ба шинжилгээний сорьц бэлдэх.	MNS ISO 3100-1:2000
3	Мах, махан бүтээгдэхүүн. Махны шинэлэг байдлыг тодорхойлох шинжилгээний арга	MNS 1161:2002
4	Мах, махан бүтээгдэхүүн. Маханд хийх шинжилгээний арга ба мал эмнэлэг, ариун цэврийн шинжилгээний зарчим	MNS 4080:88
5	Микробиологи. Салмонелл илрүүлэх ерөнхий заавар	MNS ISO 6579:99
6	Хүнсний бүтээгдэхүүн дэх малын эм, бэлдмэлийн үлдэгдлийн агууламжийг тодорхойлох өрсөлдөөнт иммуноферментийн арга	MNS 6569:2016

Дээрх стандарт, дүрмүүдийн дэлгэрэнгүйг Стандарт, хэмжилзүйн газрын лавлагаанаас болон <http://estandard.gov.mn/> цахим хуудсаар орж авч болно.

Мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрүүдийн хянан магадалгаа: Мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрүүд Монгол улсын холбогдох хууль тогтоомжуудын хүрээнд, холбогдох стандарт шаардлагуудыг хангасан байх ёстой бөгөөд МЭЕГ болон МХЕГ-аас дараах шалгах хуудаснуудын хүрээнд хяналт, шалгалт хийнэ.

1. Мах эхлэн боловсруулах үйлдвэрийг шалгах хяналтын хуудас
2. Мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийн эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг шалгах хяналтын хуудас
3. Махны хадгалалтын нөхцөлийг шалгах хяналтын хуудас
4. Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас
5. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн экспортлох үеийн хяналтын хуудас
6. Махны үйлдвэрлэл шинээр эрхлэгчдэд урьдчилсан хяналт хийх хяналтын хуудас (<https://www.mongolchamber.mn/p/41>)

2.3 БНХАУ-ЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ, НЭВТРЭХ ҮЙЛ ЯВЦ

1. Зах зээлийн ерөнхий зохицуулалтууд

Дулааны аргаар боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүн БНХАУ-ын зах зээлд экспортлохыг зорьж байгаа экспортлогчид БНХАУ-ын хүнсний аюулгүй байдал, хүнсний эрүүл ахуйн шаардлагыг нарийвчлан ойлгох ёстой.

БНХАУ-д импортлох үхрийн махны боловсруулах үйлдвэрүүдэд дараах стандартын шаардлагууд тавигдаж байна.

- “Hazard Analysis and Critical Control Point (HACCP) System - General Requirements for Food Processing Plant”, National Standard of the PRC, GB/T 27341-2009
- “National Food Safety Standard Hygienic Specification for Livestock and Poultry Slaughtering and Processing”, National Standard of the PRC, GB 12694-2016
- General Rules for the Labelling of Prepackaged Foods, National Standard of the PRC, GB 7718 2011

Дээрх стандартууд болон холбогдох стандартуудыг БНХАУ-ын Стандартын Удирдлагын Газрын цахим хуудас (<http://www.sac.gov.cn/>)-аас авах боломжтой.

Экспортлогчид бүтээгдэхүүнийг экспортлохоосоо өмнө зах зээлд нэвтрэх боломжийг хангах ёстой. Экспортын хүнсний бүтээгдэхүүн Монгол Улс, БНХАУ-ын био аюулгүй

байдал, хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлын дүрэм журмыг дагаж мөрдөх мөн түүнчлэн шошго, сав баглаа боодлын шаардлагад нийцсэн байх нь чухал ач холбогдолтой юм.

БНХАУ-ын хууль тогтоомжийн дагуу экспортолсон мах, махан бүтээгдэхүүнтэй холбоотой ямар нэгэн хариуцлагыг экспортлогч хүлээнэ. БНХАУ-д импортлохоос татгалзаж буй бүтээгдэхүүний ихэнх хувийг био аюулгүй байдлын шаардлага, бүтээгдэхүүний найрлага, сав баглаа боодол, хаяг шошгоны стандарт хангаагүй зэрэг зөрчлүүдтэй холбоотой байна.

БНХАУ-д Монгол Улсаас үхрийн мах экспортлоход тарифын бус дараах шаардлагууд тавигдаж байна.

- Мал нядлах, мах боловсруулах үйлдвэрт тавигдах стандартын шаардлагууд
- Малын гарал үүслийн шаардлагууд (Гарын авлагын 4-р бүлгээс үзнэ үү)
- Мал эмнэлгийн шаардлагууд (Гарын авлагын 4-р бүлгээс үзнэ үү)
- Бүтээгдэхүүний хорио цээрийн шаардлагууд (Гарын авлагын 2.4 хэсгээс үзнэ үү)
- Тээвэрлэлтийн шаардлагууд (Гарын авлагын 3.4 хэсгээс үзнэ үү)
- Сав баглаа боодол, хаяг шошгоны шаардлагууд (Гарын авлагын 3.3 хэсгээс үзнэ үү)

Тарифын зохицуулалт.

БНХАУ-д Монгол Улсаас HS 0202 Үхрийн хөлдүү мах ангиллаар тарифын нэн тааламжтай нөхцөл (MFN)-өөр 12% , HS 1602 Дулааны аргаар боловсруулсан үхрийн мах ангиллаар тарифын нэн тааламжтай нөхцөл (MFN)-өөр 5% , HS 0201 Үхрийн шинэ мах , хөргөсөн мах ангиллаар тарифын нэн тааламжтай нөхцөл (MFN)-өөр 12% байна (<https://www.macmap.org/en/query/compare-competitor?reporter=156&partner=All&product=0205>).

БНХАУ-ын хүнсний бүтээгдэхүүний импортын асуудлыг Төрийн зөвлөлийн харьяа “Зах зээлийн удирдлага зохицуулалтын газар (SAMR)” болон “Гаалийн ерөнхий газар (GACC)” нь удирдлага, зохицуулалтаар ханган ажиллаж байна.

2. БНХАУ-ын холбогдох хууль, эрх зүйн баримт бичиг

Одоогийн байдлаар БНХАУ-ын хүнсний экспорт, импортын аюулгүй байдлыг зохицуулдаг 30 гаруй хууль, дүрэм, журам үйлчилж байна. Эдгээрийн үндсэн суурь, чухал хууль нь БНХАУ-ын “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хууль” юм. Энэхүү хуульд хүнсний үйлдвэрлэл, хангамжийн сүлжээ, түгээх, борлуулах, эргүүлэн татах үйл явц дахь алхам бүрийг хянах замаар эрсдэлээс урьдчилан сэргийлэх, мөн хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуйн шаардлага, зохицуулалтууд илүү чухалчлан тусгагдсан байна. Тус хуульд үндэсний, орон нутгийн зохицуулах байгууллагуудад илүү их эрх мэдэл олгож, зөрчилд хатуу шийтгэл оноож, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, импортлоход чиглэсэн тодорхой заалтууд орсон байна.

Дулааны аргаар боловсруулсан үхрийн мах, үхрийн махан бүтээгдэхүүн экспортлох үйл ажиллагаа нь БНХАУ-ын дараах гол гол хууль тогтоомжуудад нийцэх ёстой бөгөөд, холбогдох импортын татварын хувь хэмжээ, бичиг баримт, лиценз, чанар, хорио цээр, гарал үүсэл, импортын хяналтын талаарх мэдээлэл, шаардлагуудыг эдгээр хууль, журмуудаас харах боломжтой.

- “Хүнсний аюулгүй байдлын тухай хууль” (http://www.gov.cn/zhengce/2015-04/25/content_2853643.htm)
- “Импорт, экспортын бараа бүтээгдэхүүний хяналт шалгалтын тухай хууль” , түүнийг хэрэгжүүлэх журам (http://www.cnca.gov.cn/bsdt/ywzl/flyzcyj/zcfg/200809/t20080925_36653.shtml)

- “БНХАУ-ын амьтан, ургамлын хорио цээрийн тухай хууль” ,түүнийг хэрэгжүүлэх журам
(http://www.npc.gov.cn/wxzl/gongbao/2000-12/05/content_5004560.htm)
- “БНХАУ-ын хилийн эрүүл мэнд, хорио цээрийн тухай хууль” ,түүнийг хэрэгжүүлэх журам (<http://cs.mfa.gov.cn/zlbq/flfg/crjxg/t266914.shtml>)
- “Хүнсний болон бусад бүтээгдэхүүний хяналт, удирдлагыг бэхжүүлэх талаар Төрийн зөвлөлийн тусгай журам”
(http://www.gov.cn/zwgk/2007-07/27/content_699138.htm)
- “Импортын болон экспортын махны хяналт шалгалт, хорио цээрийн байдалд хяналт тавих арга хэмжээ”. Гаалийн журам
(<http://www.customs.gov.cn/customs/302249/302266/302267/2389611/index.html>)

3. БНХАУ-ын хүнсний импортыг зохицуулах байгууллагууд

БНХАУ-ын хүнс, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний импортыг зохицуулах байгууллагууд нь Төрийн зөвлөлийн яамдын харьяанд хүнсний бодлого, хууль, дүрэм журам, тэдгээрийн хэрэгжилтийг удирдах, хянах үүрэгтэй.



Зураг 5. БНХАУ-ын хүнсний бүтээгдэхүүний импортыг зохицуулах байгууллагууд

Дээрх зурагт харуулсан зохицуулах байгууллагуудын чиг үүргийг дараах хүснэгтээр харуулж байна.

Хүснэгт 6. Зохицуулах байгууллагууд тэдгээрийн чиг үүрэг

Байгууллага	Үүрэг чиглэл	Цахим хаяг
ГАСС “Гаалийн ерөнхий газар”	<p>“Гаалийн ерөнхий газар”-нь хүнсний импорттой холбоотойгоор дараах чиг үүргүүдээр үйл ажиллагаагаа өргөжүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Мал амьтан тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүний экспорт, импортын хорио цээрийн дэглэм • Ургамлын гаралтай бүтээгдэхүүний экспорт, импортын хорио цээрийн дэглэм • Гаалийн эрсдэлийн менежмент, статистик мэдээлэл • Чөлөөт худалдааны бүсийн удирдлага • Хүнсний бүтээгдэхүүний импортлогч байгууллагын бүртгэл • Татвар хураалт • Хилийн хяналт 	<p>http://customs.gov.cn (Хятадаар)</p> <p>http://english.customs.gov.cn (Англиар)</p>

	<ul style="list-style-type: none"> •Олон улсын хамтын ажиллагаа, хоёр талын хэлэлцээрийг боловсруулж, гарын үсэг зурах. 	
SAMR “Зах зээлийн удирдлага зохицуулалтын газар”	<p>“Зах зээлийн удирдлага зохицуулалтын газар”-нь шинээр байгуулагдсан газар бөгөөд дараах чиг үүргүүдийг хэрэгжүүлнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> •Бизнесийн зөвшөөрөл, лицензийн удирдлага •Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хүнсний үйл явцын сертификат, зөвшөөрлүүд •Зах зээлийн зохицуулалтыг нарийвчлан хэрэгжүүлэх •Үндэсний хүнсний дээж, сорилын үйл ажиллагаа •Эрүүл мэндийн бүтээгдэхүүн, эмчилгээний зориулалттай бүтээгдэхүүн, нялхсын бүтээгдэхүүн •Лабораторийн гэрчилгээжүүлэлт, баталгаажуулалт •Үндэсний стандартчиллын тухай хууль тогтоомж, хууль тогтоомж гаргах, салбарын болон орон нутгийн стандартуудыг гаргах •Барааны тэмдгийн бүртгэл. 	<p>http://samr.gov.cn (Хятад хэлээр)</p>
NHCC “Хятадын үндэсний эрүүл мэндийн комисс”	<p>“Хятадын үндэсний эрүүл мэндийн хороо”-нь шинээр байгуулагдсан газар бөгөөд дараах чиг үүргүүдийг хэрэгжүүлнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> •Хүнсний аюулгүй байдлын үндэсний стандартыг бий болгох •Хүнсний шинэ түүхий эд, хүнсний шинэ нэмэлтийг бүртгэх •Үндэсний стандартгүй бүтээгдэхүүний импортын зөвшөөрөл олгох •Хүнсний аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ 	<p>http://www.nhc.gov.cn/ (Хятадаар) http://en.nhc.gov.cn/ (Англиар)</p>

4. Экспортлогч улс (бүс нутаг)-ын зөвшөөрөл

Монгол улс, БНХАУ-ын засгийн газар хооронд “Хүнсний бүтээгдэхүүний экспорт, импортын аюулгүй байдлын хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг 2009 онд байгуулж, хэлэлцээрийн 5 дугаар зүйлд тусгагдсан заалтын хүрээнд 2 жил тутамд хүнсний бүтээгдэхүүний экспорт, импортын аюулгүй байдлын дэд сайд нарын төвшний хамтын ажиллагааны механизмаар БНХАУ-д мах, махан бүтээгдэхүүн экспортлохтой холбоотой асуудлыг шийдвэрлэдэг болсон.


Экспортлогчид БНХАУ-д дулааны аргаар боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүн экспортлох улс (бүс нутаг)-аар дараах протоколуудын хүрээнд зөвшөөрөгдсөн байна. Эдгээр нь:

- Монгол Улс болон БНХАУ-ын Хөдөө аж ахуйн дэд сайд нарын төвшинд хэлэлцээр хийгдэж 2011 оны 10-р сарын 27-ны өдөр “Дулааны аргаар боловсруулсан үхэр, хонь, ямааны мах, махан бүтээгдэхүүнийг Монгол Улс, БНХАУ-д экспортолж, импортлох үеийн хяналт, шалгалт, хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн нөхцөлийн тухай Монгол Улсын Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар, БНХАУ-ын Чанарын Хяналт Шалгалт, Хорио Цээрийн Ерөнхий Газар” хоорондын протокол,
- 2016 оны 8 сарын 29 өдөр “Монгол улсын Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар болон БНХАУ-ын ЧХШХЦЕГ хооронд Монгол Улсаас БНХАУ-д экспортлох үхрийн

махны хяналт, шалгалт, хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн нөхцөлийн тухай протокол” -д гарын үсэг зурснаар үхрийн мах болон дулааны аргаар боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүн экспортлох улс (бүс нутаг)-аар хүлээн зөвшөөрөгдсөн.

5. БНХАУ-ын зах зээлд мах, махан бүтээгдэхүүн экспортлох үйлдвэрийн хянан магадалгааны үйл явц

Хоёр орны хооронд байгуулсан протоколын дагуу холбогдох байгууллагууд хянан магадалгааг дараах байдлаар хийж гүйцэтгэнэ.



Схем 1. Хянан магадалгаа хийх үйл явц

Эх сурвалж: Зөвлөх (судлаач)-ийн цуглуулсан чанарын мэдээлэл

Энэхүү үйл явцаас **үйлдвэрүүдэд** хийх хянан магадалгааг дараах хүрээнд хийнэ. Үүнд:

- ✓ Мал нядлах, мах боловсруулах үйлдвэрийн танилцуулга: (Холбогдох бичиг баримтууд: ААН-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, НАССР гэрчилгээ, ISO гэрчилгээ, Тохирлын гэрчилгээ гэх мэт)
- ✓ Нядалгаанд орж байгаа малын гарал үүсэл:(Малын гарал үүслийн гэрчилгээ, Мал эмнэлгийн лабораторийн шинжилгээний дүн гэх мэт)
- ✓ Усны хангамж (Усны сорил, шинжилгээний дүн гэх мэт)
- ✓ Хүний нөөц (Үйлдвэрийн ажилчдын эрүүл мэндийн үзлэг шинжилгээний дүн, малын эмч, байцаагч нарын бичиг баримтын хуубар гэх мэт)
- ✓ Нядалгаа, нядалгааны байр (Нядалгааны байрны мал эмнэлэг ариун цэврийн байдал, нядалгааны урсгал диаграмм, хийгддэг эрүүл ахуй ариун цэврийн заавар, удирдамж, шинжилгээ сорилын дүн гэх мэт)
- ✓ Мах, махан бүтээгдэхүүний боловсруулалтын байгууламж (Мах, махан бүтээгдэхүүнийг экспортлох шалгуурыг хангасан тухай, холбогдох хууль тогтоомжуудын дагуу эрх бүхий байгууллагуудаас авсан зөвшөөрлийн дагуу өөрийн үйлдвэрт боловсруулсан мах, махан бүтээгдэхүүн болохыг тодорхойлно)
- ✓ Бүтээгдэхүүний чанарын болон аюулгүй байдлын хяналтын (НАССР, ISO, СМР) тогтолцоо хэрэгжүүлдэг эсэх,
- ✓ Үйлдвэрлэлийн байр, технологийн тоног төхөөрөмж, эд хогшил, сав баглаа боодлын ариутгал, халдваргүйжүүлэлтийн (SSOP) тогтолцоо хэрэгжүүлдэг эсэх

- ✓ Хадгалах барилга, байгууламж, хяналтын бараа, түүхий эдийн хадгалалт тээвэрлэлтийн үеийн горимын биелэлт
- ✓ Хяналтын объектын хэмжил-зүйн багаж хэрэгслээр хангагдсан байдал,
- ✓ Үйлдвэрийн түүхий эд, бэлэн бүтээгдэхүүн, хүнсний бус бүтээгдэхүүн, сав баглаа боодлын хадгалалтын зохион байгуулалт,
- ✓ Халдваргүйтгэл хийх хэсэг/цэг байгаа эсэх, түүний байдал,
- ✓ Хөргүүртэй агуулах болон тээврийн хэрэгслийн ариутгал халдваргүйтгэл, хортон мэрэгч, шавьж устгах журам
- ✓ Бэлэн бүтээгдэхүүний түр хадгалалт болон ачилтын үеийн температур-чийгшилтийн горим,
- ✓ Мал эмнэлгийн хяналтын барааны ачих/буулгах, тээвэрлэлтийн үеийн мал эмнэлгийн дагалдах бичиг баримтын бүрдүүлэлт.
- ✓ Хөргүүр, хөлдөөгчид хэрэглэж буй амиак, фероны дугаар, төрөл, хөргүүр хөлдөөгч, гүн хөлдөөгч, агуулахын хүчин чадал
- ✓ Ажилчдын хоолны газар
- ✓ Гар угаах ариун цэвэр, угаалгын байгууламж
- ✓ Мал эмнэлгийн газраас гаргасан баталгаажуулалт (<http://www.cnca.gov.cn/bsdt/ywzl/jkspjwscpqzc/wjxz/>)

6. Экспортлогч цахим бүртгэлд хамрагдах дугаар авах

БНХАУ-д үхрийн мах, үхрийн махан бүтээгдэхүүн экспортлох компаниудад БНХАУ-ын “Гаалийн Ерөнхий Газар”-ын харьяа “Баталгаажуулалт итгэмжлэлийн газар”-аас үйлдвэр дээрх хянан магадалгаа хийх бөгөөд мах боловсруулах үйлдвэрүүдэд энэхүү гарын авлагын 2.3-д дурдсан БНХАУ-ын стандартууд болон хоёр орны хооронд байгуулагдсан протокол, мөн 2.2-д дурдсан Монгол Улсын холбогдох хууль, стандартуудын шаардлагуудыг хангасан байх шаардлага тавигдана.

БНХАУ-ын зах зээлд дулааны аргаар боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүн экспортлохыг зорьж байгаа компани (хянан магадалгаанд тэнцсэн)-ууд БНХАУ-ын хүнсний бүтээгдэхүүний импортын бүртгэлд бүртгэгдсэн байх ёстой. Цахим бүртгэлийн маягт болон бүртгэлийн талаарх нэмэлт мэдээлэл авах, экспортлогчоор бүртгүүлэхдээ дараах цахим хуудсанд хандана уу (<http://ire.customs.gov.cn>).

БНХАУ-д дулааны аргаар боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүн экспортлохоор хүсэлт гаргагч нь дараах линкээр орж өргөдлийн маягтыг татан авна уу <http://www.cnca.gov.cn/bsdt/ywzl/jkspjwscpqzc/wjxz>

Хэрэв экспортлогч компани нь БНХАУ-ын бүртгэлийн шаардлагыг хангасан гэж үнэлэгдсэн бол БНХАУ-ын Итгэмжлэл, Баталгаажуулалтын Газрын цахим хуудас (<http://www.cnca.gov.cn/bsdt/ywzl/jkspjwscpqzc>), эсвэл Гаалийн Ерөнхий Газрын цахим хуудас (<http://www.customs.gov.cn/customs/jy/jy/dzwjyjy/qymd/index.html>)-аар олон нийтэд мэдээлнэ.

2.4 БНХАУ-Д ЭКСПОРТЛОХ ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХОРИО ЦЭЭР

Монгол Улсын Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар, БНХАУ-ын Чанарын Хяналт Шалгалт, Хорио Цээрийн Ерөнхий Газар хоорондын 2011 оны 10-р сарын 27-ны өдөр байгуулсан “Дулааны аргаар боловсруулсан үхэр, хонь, ямааны мах, махан бүтээгдэхүүнийг Монгол Улс, БНХАУ-д экспортолж, импортлох үеийн хяналт, шалгалт,

хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн нөхцөлийн тухай” протокол (1602-д хамаарах) болон 2016 оны 8 сарын 29 өдөр байгуулсан Монгол Улсаас БНХАУ-д экспортлох үхрийн махны хяналт, шалгалт, хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн нөхцөлийн тухай” протокол (0201 болон 0202-д хамаарах)-уудад тусгасан бүтээгдэхүүнд тавигдах нийтлэг (ижил төстэй) дараах шаардлагуудыг хангана. Үүнд:

- Монгол Улсын газар нутагт үхрийн мялзан, үхрийн цээж, үхрийн тархи сархиатах, рифт хөндийн халуурал, лимфийн зангилаат үрэвсэл, мялзан төст зэрэг өвчнөөр тайван байх,
- Шүлхий өвчнөөр тайван бүс нутагт сүүлийн 12 сар шүлхийн өвчин илрээгүй байх,
- Монгол Улс нядалгаанд орсон үхэр хаана төрж, бойжсон, тэдгээрийг хаанаас гаралтай болохыг тогтоох үүднээс үр дүнтэй ул мөрийг мөрдөн мөшгөх тогтолцоог ашигласан байх,
- Монгол Улс хивэгч амьтны гаралтай /сүү, сүүн бүтээгдэхүүнээс бусад/ зөвхөн арьс, ширнээс гарган авсан цэлцэгнүүр, коллаген, дикальцифосфат /уураг болон өөхний үлдэгдэлгүй/ агуулсан тэжээлээр хивэгч амьтныг тэжээхийг хориглох, мөн хянах тогтолцоотой байх,
- Бэлтгэх үхэр нь Монгол Улсын шүлхий өвчнөөр тайван, вакцин хэрэглэдэггүй бүс нутагт төрж бойжсон байх, мөрдөн тогтоож болохуйц давтагдахгүй таних тэмдэгтэй байх,
- Шүлхий өвчнөөр тайван аймгуудад бусад аймгаас сүүлийн 12 сарын хугацаанд салаа туурайтай амьтан оруулаагүй байх,
- Экспортлох маханд ямар нэгэн химийн бодисын үлдэгдэл, эм, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болохуйц хортой болон аюултай үлдэгдэл агуулаагүй байх,
- Тухайн бүс нутагт сүүлийн 6 сарын хугацаанд ямар нэгэн мал, амьтны өвчний улмаас хорио цээрийн дэглэм тогтоогоогүй байх,
- Тухайн бүс нутагт сүүлийн 6 сарын хугацаанд цэврүүт амтас, хэл хөхрөх, сүрьеэ, боом, галзуу, бруцеллёз, Ауски өвчин, ку-чичрэг, зүрх усжих (heartwater) болон иж сүрьеэ зэрэг өвчин гараагүй байх,
- Мал нь нядлагдахаас доод тал нь 6 сарын өмнө тухайн сум (тайван бүс)-д байрласан байх,
- Нядалгаанд орохоос 14 хоногийн өмнө эсвэл түүнээс урт хугацаанд боомын амьд вакцинд таригдаагүй байх,
- Мал нь БНХАУ болон Монгол Улсад хориотой малын эм, хүнсний нэмэлт хэрэглээгүй байх,
- Нядалгааны өмнөх болон дараах хяналтаар үхрийн сүрьеэ, боом, бруцеллёз зэрэг өвчний шинж тэмдэг илрээгүй байх,
- Махыг БНХАУ-д экспортлох махны үйлдвэр (нядалгаа, боловсруулах, хадгалах) нь шүлхий өвчнөөр тайван, вакцин хэрэглэдэггүй бүс нутагт байрлах, мөн БНХАУ болон Монгол Улсын баталсан хууль тогтоомжийн дагуу эрүүл ахуй, мал эмнэлгийн шаардлагыг хангасан байх,
- Мал, амьтны халдварт өвчин, шимэгч хорхойн эмнэл зүйн шинж тэмдэггүй, гулууз болон дотор эрхтэнд ямар нэгэн эмгэг өөрчлөлтгүй байх,
- Нядлагдсан малын гулууз махыг шулахаас өмнө +2 хэмээс дээш дулаан орчинд доод тал нь 24 цаг сэврээнэ. Гулууз махны рН нь ясгүй махны гүнд 5.9-өөс ихгүй, гулууз мах нь тунгалгийн зангилаа болон булчирхайн эдгүй болохыг баталгаажуулсан байх,
- Мах нь НАССР-д суурилсан чанарын хяналтын тогтолцооны хөтөлбөртэй үйлдвэрт бэлтгэгдсэн байх, ямар нэгэн өвчин үүсгэгч бичил биетээр бохирдоогүй байх,

- Бүтээгдэхүүн дэх мал эмнэлгийн эм, пестицид, хүнд металл, хортой болон аюултай бодисын үлдэгдлийн хэмжээ БНХАУ болон Монгол Улсад зөвшөөрөгдөх үлдэгдлийн дээд хэмжээнээс хэтрээгүй, хоёр улсад хэрэглэхийг хориглосон бодис агуулаагүй байх,
- Мах нь хүний хэрэгцээний шаардлагыг хангасан, аюулгүй болохыг баталгаажуулах,
- Дээрх шаардлагуудыг хангаагүй бусад үхэртэй хамт нядалж болохгүй,
- Шаардлага хангаагүй малаас бэлтгэгдсэн махтай хамт боловсруулж болохгүй,
- Экспортлох махыг бусад махнаас тусдаа, зориулалтын өрөөнд хадгалах,
- Экспортлох махны дотор болон гаднах баглаа, боодол нь олон улсын эрүүл ахуйн стандартад нийцсэн хоргүй, аюулгүй шинэ материалаар хийгдсэн байх,
- БНХАУ-д экспортлох махны савлалт, хадгалалт, тээвэрлэлт зэрэг бүхий л экспортлох үйл явц нь ариун цэврийн шаардлагад нийцсэн байх ба хорт болон аюултай бодисоор бохирлогдохоос сэргийлсэн байх,
- Тээвэрлэлтийн явцад мах нь өвчний улмаас хязгаарлалтад орсон эсвэл тандалтад хамрагдаж байгаа нутаг дэвсгэрээр дайран өнгөрч болохгүй,
- Тээвэрлэлтийн явцад баглаа боодлыг сольж, онгойлгож болохгүй ба хөлдөөсөн махны гүний хэм нь -18 хэмээс ихгүй байх.

Мөн дулааны аргаар боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүн (1602)-д дээрх хорио цээрийн шаардлагуудаас гадна дараах дулааны боловсруулалттай холбоотой шаардлагууд тавигдана. Үүнд:

- Усанд буцалгах, жигнэх болон тосонд шарахдаа үхрийн мах болон түүний гаралтай бүтээгдэхүүний төв хэсгийн дулааныг +80 хэм болон түүнээс дээш температурт хүргэж 5 минут болон түүнээс дээш хугацаанд байлгана. Эсхүл бусад ямар ч арга хэрэглэсэн үхрийн мах болон түүний гаралтай бүтээгдэхүүний төв хэсгийн дулааныг +70 хэм болон түүнээс дээш температурт хүргэж 30 минут байлгана.
- Үйлдвэрлэгч аж ахуй нэгж тусгай хүн томилж бүтээгдэхүүнийг халаасны дараа төв хэсгийн дулааныг хэмжиж, махыг зүсэж мэдрэхүйн шинжилгээ хийж, үйлдвэрлэх явцын дунд тэмдэглэл хийн, эцсийн бүтээгдэхүүний микроорганизмын үзүүлэлтийг шалгаж, шаардлагатай үед уургийг денатурат болгох туршилтыг хийж бүтээгдэхүүн бүрэн боловсорсон эсэхийг баталгаажуулна.

Үүнээс гадна дулааны аргаар боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүний мэдрэхүйн үнэлгээг дараах байдлаар үнэлнэ.

№	Үзүүлэлт	Шинж чанар
1	Биет байдал	Хатаж харлаагүй, жигд өнгөтэй, хуйхгүй, гаднын бохирдолгүй
2	Өнгө	Гадаргуу нь жигд бор шаргал өнгөтэй, өөх нь цагаанаас цайвар шаргал өнгөтэй
3	Үнэр	Чанасан махны өвөрмөц үнэртэй, гаднын үнэргүй
4	Зүсэлтэнд	Зүсээд гэсгээж шахаж үзэхэд шүүс нь улаан бус гүйцэт болцтой, жигд бор шаргал өнгөтэй

2.5 БҮЛГИЙН ШАЛГАХ ХУУДАС

Мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын шаардлагад нийцсэн эсэх

БНХАУ-ын стандартын шаардлагад нийцсэн эсэх

Экспортлох бүтээгдэхүүн нь Монгол Улс болон БНХАУ-ын холбогдох байгууллагуудын хооронд байгуулсан протоколоор зохицуулагдсан эсэх

Үйлдвэр нь БНХАУ-ын ГЕГ-аар хянан магадлагаа хийлгэсэн эсэх

Экспортлогч нь БНХАУ-ын ГЕГ-ын цахим бүртгэлд хамрагдаж, дугаар авсан эсэх

Монгол Улс болон БНХАУ-ын холбогдох байгууллагуудын хооронд байгуулсан протоколын бүтээгдэхүүний хорио цээрийн шаардлагыг хангасан эсэх

ГУРАВ. БНХАУ-Д ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХ БЭЛТГЭЛ АЖИЛ

БНХАУ-д дулааны аргаар боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүн экспортлох бэлтгэл ажил нь дараах алхмын дагуу явагдана.




Зураг 6. БНХАУ-д дулааны аргаар боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүн экспортлох бэлтгэл ажил

3.1 ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

3.1.1 ГЭРЭЭ БАЙГУУЛАХ БЭЛТГЭЛ АЖИЛ

Гэрээний гол нөхцөлүүдийн талаар талууд харилцан тохиролцож, хуулийн хүрээнд гэрээг дараах үе шатуудын дагуу байгуулна.



БНХАУ-д дулааны аргаар боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүн экспортлохын тулд боломжит импортлогч (худалдан авагч)-ийг олж, хэлэлцээ хийнэ.

Импортлогч буюу худалдан авагчаа олох, сонгох: Боломжит импортлогч (худалдан авагч)-ийг хайх, сонгоход дараах арга, хэлбэрүүдээс ашиглаж болно. Үүнд:

- Үзэсгэлэн яармагт оролцох,
- Бизнес уулзалт хийх,
- Цахим шуудангаар харилцаа тогтоох,
- Wechat, Weibo, QQ болон Skype гэх мэт нийгмийн сүлжээ ашиглах.
- БНХАУ-ын импортлогч (худалдан авагч)-ийн цахим хуудас ашиглах (вэб сайт)

- Хайлтын систем (www.alibaba.com, www.taobao.com болон www.baidu.com)
- Шууд болон шууд бус зар сурталчилгаанаас гэх мэт.

3.1.2 ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

Экспортын гэрээ нь худалдах, худалдан авах гэрээ байна. Энэхүү гэрээг байгуулахад “Бараа худалдах-худалдан авах олон улсын гэрээ”-ний тухай НҮБ-ын конвенцыг⁵ баримтална (Венийн конвенц). Дараахь хүснэгтэд гэрээний заалт тус бүрээр анхаарах зүйлсийг тоймлон харууллаа (Хүснэгт 7).

Хүснэгт 7. Гэрээний заалтууд, анхаарах зүйлс:

№	Гэрээний заалт	Анхаарах зүйлс
1	Удиртгал хэсэг	✓ Энэ хэсэгт гэрээний нэр, дугаар, гэрээг байгуулсан газар, цаг хугацаа, талуудын нэр, хаяг, эрх зүйн байдал зэргийг тусгаж өгдөг.
2	Гэрээний зүйл	✓ Тухайн худалдах-худалдан авах гэрээний дагуу худалдах зүйл болох барааг маш нарийн, үнэн зөв тодорхойлж бичнэ. ✓ Гэрээний зүйл нь барааны нэр төрөл, тухайн гэрээний харилцааг зохицуулахад сонгон авах эрх зүйг тодорхойлох нэг хүчин зүйл болдог.
3	Тоо хэмжээ	✓ Худалдах худалдан авах гэрээнд барааны тоо, хэмжих нэгж, жин хэмжүүрийн системийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай. ✓ Олон улсын стандартын хэмжүүрийн системийн тоон нэгжийг хэрэглэх, мөн нийт жин (Gross weight), цэвэр жин (Net weight)-г нарийвчлан тусгах.
4	Чанар	✓ Чанаж боловсруулсан мах, Техникийн ерөнхий шаардлага /MNS 6790:2019/-ын дагуу боловсруулсан.
5	Барааны үнэ	✓ Барааны үнийг талууд харилцан ашигтай байдлаар тохиролцож, нэгжийн болон нийт үнийг тусгана. ✓ Гэрээнд хэрэв валютаар үнэ тооцох бол валютын ханшийн өөрчлөлтийг тооцоолох. ✓ Гэрээний үнийг хатуу, хөдөлгөөнт, хэлбэлзэх зэргээр тогтоож болно.
6	Баглаа, боодол, шошго, тэмдэг	✓ Гэрээнд баглаа боодлын овор хэмжээ, шинж байдлын талаар тусгана. ✓ Ихэвчлэн барааны үнэд баглаа боодлын үнийг оруулж тооцдог. ✓ Баглаа, боодол, шошго тэмдэгийн шаардлагуудыг энэхүү гарын авлагын 3.3 хэсгээс харна уу.
7	Барааг хүлээлгэн өгөх, авах	✓ Зохих тоо, чанарын барааг хүлээн авах, хүлээлгэн өгөх ажлыг урьдчилан тохиролцсон газар (боомт)-т хэрхэн зохион байгуулах талаар нарийвчлан тусгана. ✓ Зохих тоо, чанарын барааг хүлээн авах, хүлээлгэн өгөх үеийн актыг хэрхэн гүйцэтгэх, алдаа, дутагдал гарвал хэрхэн шийдэх талаар тусгах.
8	Тээвэрлэлтийн нөхцөл	✓ Тээвэрлэлтийн хугацаа, нөхцлийн талаар тусгана. ✓ Тээвэрлэлтийн үеийн хорио цээр, техникийн нөхцөл, шаардлагын талаар энэхүү гарын авлагын 2.4 хэсгээс харна уу.

⁵ <https://www.legalinfo.mn/law/details/1220>

9	Төлбөр тооцоо	<ul style="list-style-type: none"> ✓ Төлбөр ачилтын өмнө, хойно эсвэл хослуулан хийх эсэх ✓ Төлбөр төлөх хугацаа ✓ Төлбөр тооцоо хийх банк, валют, дансны талаарх мэдээлэл ✓ Төлбөр төлөх хэлбэрээ сонгох (аккредитив, инкасс, нээлттэй данс, шилжүүлэг, эскроу данс) энэхүү гарын авлагын 3.2 хэсгээс харна уу.
10	Нийлүүлэх газар, хугацаа	<ul style="list-style-type: none"> ✓ Инкотермсийн нөхцлүүдээс аль болох өөрт ашигтай хувилбарыг сонгож худалдан авагчтай тохиролцох. ✓ Сонгосон Инкотермсийн нөхцлөөс шалтгаалан барааг нийлүүлэх газар болон хугацаа, түүнчлэн бичиг баримт бүрдүүлэх, зардал болон эрсдэл хуваарилах зэрэг асуудлыг тусгана. Энэхүү гарын авлагын Хүснэгт 8-аас харна уу.
11	2 талын үүрэг, хариуцлага	<ul style="list-style-type: none"> ✓ Гэрээнд худалдагч, худалдан авагч талуудын хүлээх үүрэг, хариуцлагуудыг нарийвчлан тусгана.
12	Маргаан	<ul style="list-style-type: none"> ✓ Маргаан гарсан үед хэрхэн шийдвэрлэх талаар тусгах. Энэхүү гарын авлагын 3.1.3 хэсгээс харна уу.
13	Давагдашгүй хүчин зүйл	<ul style="list-style-type: none"> ✓ Ямар нөхцөлийг давагдашгүй хүчин зүйл гэж үзэх ✓ Давагдашгүй хүчин зүйл гарсан тохиолдолд хэн баталгаажуулах зэргийг тусгана.
14	Бусад	<ul style="list-style-type: none"> ✓ Нэмэлт өөрчлөлтийг ямар тохиолдолд оруулж болох ✓ Ямар хэл дээр хэдэн хувь үйлдэгдсэн, бүгд хуулийн хүчин төгөлдөр эсэх ✓ Гэрээнд гарын үсэг зурах эрх бүхий этгээд

Инкотермс (international commercial terms)-ын нөхцөлийг худалдааны гэрээ байгуулж буй талууд сайн дураараа хэрэглэхээр тохиролцон ашиглаж болно. Энэхүү нөхцөлийг энгийнээр тайлбарлавал, худалдааны нийлүүлэлтийн үйл ажиллагааг зохицуулах заавар гэж ойлгож болно. Өөрөөр хэлбэл барааг худалдагч тал, худалдан авагч талд нийлүүлэхэд тээвэрлэх тээврийн төрөл, тээврийн зардал, эрсдэл, эрсдэлийн зардал, даатгал зэргийг аль тал нь хариуцах, барааг хүргэх газрыг сонгох зэргийг дээрх нөхцөлөөр тодорхойлсон байдаг. 2019 оны 9 сард Олон улсын худалдааны зөвлөл “Инкотермс 2020”-ийг баталсан байна.

Инкотермсийн ямар нөхцөлийг сонгосноос хамаарч хүргэлтийн үе шатуудад талуудын хүлээх үүрэг хариуцлага өөр өөр байдаг. Хүснэгт 8-д борлуулагч талын эрсдэл, зардал, даатгалыг инкотермсийн нөхцөлүүд тус бүрээр хэрхэн хариуцахыг харуулав.

Хүснэгт 8. Инкотермс 2020

Инкотермсийн нөхцөлүүд	Борлуулагч тал	Гааль	Ачилт	Тээвэрлэлт	Нэрлэсэн газар	Боомт	Тээвэрлэлт	Боомт	Нэрлэсэн газар	Тээвэрлэлт	Гааль	Буулгалт	Худалдан авагч
EXW	■												
FCA	■ ■												
FAS	■ ■ ■												
FOB	■ ■ ■ ■												
CFR	■ ■ ■ ■ ■												

■ ЭРСДЭЛ
■ ЗАРДАЛ
■ ДААТГАЛ

ДАЛАЙН ТЭЭВЭР

CIF				
CPT				
CIP				
DAP				
DPU				
DDP				

Эх сурвалж: www.iccwbo.org

3.1.3 ГЭРЭЭНЭЭС ҮҮССЭН МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

Гэрээний маргаан гарсан тохиолдолд гэрээний талууд дараах сонголтуудаар шийдвэрлэх боломжтой.

1. Харилцан тохиролцож эвлэрэх (Харилцан тохиролцож эвлэрсэн тохиолдолд зардал болон хугацаа хэмнэх боломжтой)
2. Арбитраар шийдвэрлүүлэх (Энэ тохиолдолд талууд гэрээнд арбитраар шийдвэрлүүлэх заалт оруулах ёстой, БНХАУ, Монгол улсын үндэсний болон олон улсын арбитраар шийдвэрлүүлэх)
3. Шүүхээр шийдвэрлүүлэх (Шүүхийн процесс нь тодорхой хугацаа шаардана. Мөн өмгөөллийн болон шүүхийн зардлыг тооцоолох шаардлагатай)

3.2 ТӨЛБӨР, ТООЦОО

Худалдагч, худалдан авагч талууд гэрээнд заасан барааны үнэ, торгууль, алданги, хөнгөлөлт, урамшуулал, хорогдуулсан үнэ зэргийг тооцож төлбөр тооцоог гэрээнд заасан нөхцлөөр хийж дуусгаснаар гэрээ хүчин төгөлдөр хэрэгжинэ.

БНХАУ-ын аж ахуй нэгжүүдтэй гэрээ хийхдээ төлбөрийн нөхцлөө маш сайн тохиролцох хэрэгтэй бөгөөд банкаа сонгох, төлбөр хийгдэх хугацаа, эрсдэл, эрсдлийг шилжүүлэх зэрэг нь маш чухал юм. Монгол улсад ажиллаж байгаа арилжааны банкнуудаас гадаад худалдаанд ашиглах төлбөрийн нөхцлүүдийн талаар сайн судалж өөрт ашигтай хувилбарыг гэрээнд тусгахыг эрмэлзэх хэрэгтэй.

Гадаад худалдаа хийхэд ашиглах боломжтой зарим төлбөрийн нөхцлүүдийг харууллаа (Хүснэгт 9).

Хүснэгт 9. Төлбөрийн нөхцөлүүд ба эрсдэл

Төлбөрийн нөхцөл	Төлбөрийн эрсдэл		Банкны нэмэлт баталгаа
	Экспортлогч тал	Импортлогч тал	
Нээлттэй данс (Open account)	++++	+	Шаардана
Инкасс (Collection)	+++	++	Шаардана
Аккредитив (Letter of Credit - LC)	++	+++	Шаардана
Урьдчилсан төлбөр (Advance payment)	+	++++	Шаардана

Эх сурвалж: Trade Finance Options, XAAN BANK in Mongolia

Дээрх төлбөрийн нөхцөлүүдийг товч авч үзвэл:

1. “Нээлттэй данс” төлбөрийн нөхцөл нь захиалагчид ачаа бараа ирсний дараа төлбөрөө төлөх бөгөөд энэхүү төлбөрийн нөхцөл нь ихэвчлэн 30, 60 эсвэл 90 хоногийн хугацаатай байдаг.
2. “Инкасс” төлбөрийн нөхцөл нь банк худалдагч (экспортлогч) -ийн өмнөөс худалдан авагч (импортлогч) -д баримт хүргүүлж, төлбөр нэхэмжлэн авах замаар төлбөр гүйцэтгэх үйл ажиллагаа юм.
3. “Аккредитив” төлбөрийн нөхцөл нь худалдан авагч (импортлогч) ийн банкнаас худалдагч (экспортлогч) талд хандан гаргаж буй хууль ёсны төлбөрийн баталгаа юм.
4. “Урьдчилсан төлбөрт” төлбөрийн нөхцөл нь худалдан авагч (импортлогч) ачааг тээвэрлэхээс өмнө урьдчилан төлөх төлбөрийн нөхцөл бөгөөд зээлийн картын төлбөр ба мөнгөн гуйвуулга (цахимаар төлбөр тооцоо хийх) хэлбэрүүдийг илүү түгээмэл ашигладаг.

3.3 ЭКСПОРТОД ГАРГАХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ САВ БАГЛАА БООДОЛ, ХАЯГ ШОШГО

3.3.1 САВ, БАГЛАА, БООДЛЫН СТАНДАРТ, ТУСГАЙ ШААРДЛАГА

Сав, баглаа, боодол, шошго тэмдэг нь хоёр орны хооронд хийгдсэн протоколуудад тусгасан шаардлагууд, Монгол улсын хууль тогтоомж, техникийн нөхцөл, холбогдох стандартууд, мөн импортлогч орноос тавьж байгаа мал эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн шаардлагуудад нийцсэн байна.

Хоёр орны хооронд байгуулсан дулааны аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүний сав, баглаа, боодол, шошгонд дараах шаардлагуудыг тавьсан байна.

Импортлогч орон руу гаргах боловсруулсан бүтээгдэхүүнийг олон улсын ариун цэврийн стандартыг хангасан шинэ материалаар боож баглана. Гадна баглаан дээр монгол, хятад, англи хэлээр стандарт үйлдвэрлэсэн газар, очих газар бүтээгдэхүүний нэр, жин үйлдвэрлэгчийн нэр, бүртгэлийн дугаар, үйлдвэрлэлийн цувааны дугаар, хадгалах нөхцөл, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа, хоёр талаас тэмдэглэсний дагуу хяналт шалгалт, хорио цээрийн нөхцлийг хангасан тэмдэглэгээг заасан байна. Дотор баглаан дээр үйлдвэрлэгч орны нэр бүтээгдэхүүний нэр, аж ахуйн нэгжийн бүртгэлийн дугаар, үйлдвэрлэлийн цувааны дугаарыг заасан байна. Дотор, гадна баглаан дээр мөн зөвхөн импортлогч оронд борлуулахыг заасан тэмдэглэгээг заавал хийнэ (тухайлбал, "зөвхөн Хятадын эх газарт борлуулна" "зөвхөн Монгол улсад борлуулна" гэх мэт).⁶

Мөн Монгол улсын хууль тогтоомжийн хүрээнд холбогдох стандартын шаардлагуудыг хангах шаардлага тавигдана.

Манай улсад мөрдөгдөж байгаа сав, баглаа, боодлын стандартууд:

MNS ISO 8367-2:1998	Сав баглаа боодол - Ерөнхий зориулалтын уутны зөвшөөрөгдөх хэмжээ 2-р хэсэг: Нийлэг хальсан уут 2010 оны 05 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан.	3х
----------------------------	---	----

⁶

<https://resource4.sodonsolution.org/mongolchamber/File/2019/10/17/7rwcg0qoc337woas/protokol.pdf>

MNS 6382:2013	Сав баглаа боодлын зориулалттай үелээт картон. Техникийн шаардлага.	4x
MNS 5684:2006	Сав баглаа боодлын материалд агуулагдах, хүнсний бүтээгдэхүүнд шилжиж болзошгүй химийн бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ.	7x
MNS OIML R 87:2008	Савласан бүтээгдэхүүний тоо хэмжээ	15x
MNS ISO 780:2004	Баглаа боодол - Эд зүйлсийг зөөвөрлөхөд тавих зурган тэмдэглэгээ	4x
MNS 1640:1973	Сав. Үндсэн төрөл нэр томъёо.	5x

БНХАУ-аас мах махан бүтээгдэхүүний сав, баглаа, боодол, шошго, тэмдэгт өөрийн орны стандартыг мөрдөх, мөн түүнчлэн хүнсний бүтээгдэхүүнд онцгойлон тодорхой шаардлагууд тавьдаг учраас экспортлогчдын хувьд нэн түрүүнд зорилтот зах зээлийн шаардлагыг хангах нь зайлшгүй юм.

БНХАУ-ын Хүнсний аюулгүй байдлын үндэсний стандартын газраас гаргасан бүтээгдэхүүний хаяглах, шошголох ерөнхий дүрэм, стандартыг дагаж мөрдөнө ([National food safety standard General Rules for the labeling of prepackaged foods GB7718-2011](http://www.chinesestandard.net)). Энэхүү стандарт болон бусад стандартын талаарх дэлгэрэнгүйг мэдээллийг БНХАУ-ын Үндэсний стандартын газрын албан ёсны цахим хуудаснаас авч болно (<https://www.chinesestandard.net>).

3.3.2 МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНД ХЭРЭГЛЭДЭГ САВ, БАГЛАА, БООДЛЫН ТӨРЛҮҮД

Хүнсний бүтээгдэхүүний сав, баглаа, боодлыг ерөнхийд нь дараах байдлаар ангилдаг.

- Түүхий эд боловсруулалтын сав, баглаа, боодол
- Хэрэглээний сав, баглаа, боодол
- Гаднах сав, баглаа, боодол
- Тээврийн сав, баглаа, боодол.

3.3.3 ШОШГО, ХУДАЛДААНЫ ТЭМДЭГ, КОДЧИЛОЛ

Савлагааны гаднах шошго: Хятад эсвэл Англи хэлээр байна.

1. Гарал үүсэл (Улс)
2. Бүтээгдэхүүний нэр
3. Очих улс
4. Үйлдвэрлэлийн лац дугаар (Үйлдвэрлэгчийн тодорхойлсноор)
5. Үйлдвэрлэсэн огноо
6. Цэвэр жин, килограммаар (Англи)
7. Дуусах хугацаа, хадгалах хугацаа
8. Үйлдвэрийн нэр
9. Үйлдвэрийн экспортлогчоор бүртгүүлсэн зөвшөөрөлийн дугаар
10. Хөлдөөгөөд -18С хадгалсан
11. Үйлдвэрийн хаяг (Англи)
12. Хяналт хийсэн байгууллагын дардас (Англи). Монгол улсын хувьд энэ нь мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн тэмдэгийн дардас байх ба шошгоны төв хэсэгт дарагдсан байна.

产地国家: 蒙古国 COUNTRY OF ORIGIN: 1	产地名称: NAME OF PRODUCT: 2
目的地: 中华人民共和国 DESTINATION: THE PEOPLE'S REPUBLIC OF CHINA 3	
生产批号: PRODUCTION LOT 4	生产日期 (年/月/日) 5 PRODUCTION DATE
净重 (公斤) : 20 NET WEIGHT : 20 6	保质期: 12个月 EXP: 12 MONTHS 7
8	企业名称: 达尔汗肉食品有限公司 NAME OF PLANT: 
工厂注册号: 9	保持在-18度下冷藏 KEEP FROZEN AT -18C 10
去也地址: ADDRESS OF PLANT: 11	

Савлагааны доторх шошго: Хятад эсвэл Англи хэлээр байна.

1. Бүтээгдэхүүний нэр
2. Гарал үүсэл (Улс)
3. Байгууллагын дугаар
4. Үйлдвэрлэлийн лац дугаар (Үйлдвэрлэгчийн тодорхойлсноор)
5. Үйлдвэрийн бүртгэлийн дугаар

产品名称:冻马肉	1
NAME OF PRODUCT:	
产地国:蒙古国	2
COUNTRY OF ORIGIN:MONGOLIA	
马克肉制品进出口股份有限公司	3
NAME OF PLANT:	
MEAT PROCESSING FACTORY	
生产批号:	4
PRODUCTION BATCH No:	
工厂注册号:	5
PLANT REGISTRATION NO:	

3.4 ТЭЭВЭРЛЭЛТИЙН ГЭРЭЭ

Дулааны аргаар боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтийн горимыг чанд мөрдөн хийх шаардлагатай. Экспортыг зөвхөн гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгчээр дамжуулан хийх ба экспортлогч гаалийн итгэмжлэгдсэн тээврийн компанитай хийх гэрээнд дараах зүйлсийг анхаарах шаардлагатай. Үүнд:

- ✓ Хөргүүртэй чингэлэг бүхий тээвэрлэгч байна.
- ✓ Тээвэрлэлтийн температурын горимыг мөрдөж ажиллах талаар тусгах. Мах, махан бүтээгдэхүүний гүний температур нь – 18 хэмээс ихгүй байна.
- ✓ Худалдах, худалдан авах гэрээнд заагдсан ИНКОТЕРМС-ийн нөхцөлийн дагуу ачих газар, буулгах боомтыг нарийвчлан заах.
- ✓ Төлбөрийн нөхцөл.
- ✓ Боомтод очсон ачаа буухгүй тохиолдолд алданги тооцох хувийг нарийвчлан тусгах.
- ✓ Тээвэрлэгчийн буруугаас тээвэрлэлтийн горим алдагдсан, бараанд гэмтэл хохирол учирсан тохиолдолд тээвэрлэгчид хүлээлгэх хариуцлагын талаар нарийвчлан тусгах.
- ✓ Ачааг хүлээлцэх үеийн бараа хүлээлцэх акт, хүлээлцэх үеийн үйл ажиллагааг нарийвчлан тусгах.
- ✓ Маргаан гарсан тохиолдолд хэрхэн шийдвэрлэх талаар тусгах.

Ачаа бараа тээвэрлүүлэх, тээвэрлэх гэрээний жишиг загварыг хавсралт 8-с харна уу.

3.5 БҮЛГИЙН ШАЛГАХ ХУУДАС

БНХАУ-ын шаардлага хангасан импортлогч (худалдааны түнш)-ийг олсон эсэх

Төлбөр тооцооны нөхцлийг худалдан авагч талтай харилцан тохиролцсон эсэх


Худалдааны гэрээ байгуулсан эсэх

Экспортлох бүтээгдэхүүний сав, баглаа, боодол, хаяг, шошгыг стандартад нийцүүлэн бэлдсэн эсэх

Тээврийн гэрээг гаалийн итгэмжлэгдсэн тээврийн компанитай байгуулсан эсэх

ДӨРӨВ. БНХАУ-Д ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХ ҮЙЛ ЯВЦ

БНХАУ-д дулааны аргаар боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүн экспортлох үйл явцыг дараах зургаар харуулав.




Зураг 7. БНХАУ-д дулааны аргаар боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүн экспортлох үйл явц

4.1 ГЭРЧИЛГЭЭ, ЗӨВШӨӨРӨЛ

4.1.1 СТРАТЕГИЙН ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХ ЗӨВШӨӨРӨЛ

Үхрийн мах болон дулааны аргаар боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүн экспортлогч үйлдвэр, аж ахуйн нэгж нь Монгол Улсын ХХААХҮЯ-аас стратегийн хүнс экспортлох зөвшөөрөл (квот) авна. Энэхүү зөвшөөрөл авах үйл явцыг дараах зургаар харуулав. Сонгон шалгаруулалтын хугацааг тухайн жил ХХААХҮЯ-аас тогтоож цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд мэдээлнэ.




Зураг 8. Стратегийн хүнс экспортлох зөвшөөрөл авах үйл явц

Эх сурвалж: ХХААХҮЯ, www.mofa.gov.mn

4.1.2 ДОТООДЫН МАЛ ЭМНЭЛГИЙН ГЭРЧИЛГЭЭ

Үхрийн мах экспортлох явцад хоёр удаагийн мал эмнэлгийн хяналтаар орно. Энэхүү дараалсан үйл ажиллагаа нь Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2018 оны А/51 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт, “МАЛ ЭМНЭЛГИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ЗАГВАР, ХЭРЭГЛЭХ ЗААВАР”-ын дагуу хийгдэнэ (МЭЕГ, 2018). Эхний удаад малчин, фермерээс экспортлогч, үйлдвэрлэгч хүрэх явцад анхан шатны мал эмнэлгийн нэгжийн хяналтад орж, “Мал эмнэлгийн гэрчилгээ” авах шаардлагатай. Экспортлогч мах бэлтгэлээ өөрөө хариуцаагүй тохиолдолд энэхүү гэрчилгээг нийлүүлэгч талаас шаардаж авах нь чухал юм. Мал эмнэлэг, хорио цээрийн хяналтын шинэ тогтолцоог 2018 оноос нэвтрүүлж эхлээд байгаа бөгөөд энэхүү тогтолцоонд оролцогч талууд, дарааллыг дараах схемээс харж танилцана уу.



Зураг 9. Дотоодын мал эмнэлгийн хяналтын тогтолцоо

Эх сурвалж: МХЕГ, 2018

Экспортлогч та энэхүү шат дамжлагын дагуу, зохих хяналт шалгалтыг хийлгэж, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэх нь таны бүтээгдэхүүний гарал үүслийг

баталгаажуулах бөгөөд экспортын дараагийн шатны үйл ажиллагаанд хүндрэл учрахаас сэргийлж чадна.

Хэрэв та мах бэлтгэлээ хариуцаагүй өөрийн үйлдвэрт хүлээж авч байгаа бол дээрх шат дамжлагын дагуу хяналтад орсон “Мал эмнэлгийн гэрчилгээ”-тэй бүтээгдэхүүн эсэхийг нь заавал магадлаарай. Сүүлийн жилүүдэд дэлхий нийтээр байгаль орчинд ээлтэй, гарал үүсэл нь тодорхой эргэн мөшгөх боломжтой түүхий эдээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг хэрэглэгчид хүсдэг болсон. Энэ чиглэлээр Швейцарын хөгжлийн агентлагийн Ногоон-Алт малын эрүүл мэнд төсөл, Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар (ГЗБГЗЗГ), Мал эмнэлгийн ерөнхий газар, Монголын ноос, ноолуурын холбоо, Монголын арьс ширний холбоотой хамтран “Хариуцлагатай нүүдэлчид” мөшгөх системийг олон улсын стандарт шаардлагад нийцүүлэн хөгжүүлж байна. Энэ талаарх нэмэлт мэдээллийг Хавсралт 13-д харуулав.

4.1.3 БОДЛОГЫН ГЭРЭЭ

Монгол Улсаас түүхий мах, дулааны аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүн экспортлох эрх (стратегийн хүнсний бүтээгдэхүүн экспортлох зөвшөөрөл, квот)-тэй үйлдвэр (экспортлогч) нь ХХААХҮЯ-тай бодлогын гэрээ байгуулна. Энэхүү гэрээ нь аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих, хүнсний хангамж, үнийн төвшинг тогтвортой хадгалахад чиглэгдэнэ.

Бодлогын гэрээ байгуулахад шаардагдах материалыг дараах зургуудаар харуулав.

01	• Үйлдвэрийн танилцуулга, /3 хүртэл хуудас/, хүчин чадал /хоногоор/
02	• Үйлдвэрийн хяналтын камертай эсэх, /үйл ажиллагааг хянах, бичлэг хийх, хадгалах боломжтой/
03	• Мал, мах бэлтгэж буй талаарх мэдээлэл, төлөвлөгөө, /тухайн жилд/
04	• Мал эмнэлгийн гэрчилгээ, хуулбар /үнэн/ хувь,
05	• Дайвар түүхий эдийн боловсруулалт, ашиглалт
06	• Арьс шир, /бэлтгэсэн түүхий эдийн 30-иас доошгүй хувийг дотоодын үйлдвэрт нийлүүлсэн тухай гэрээ, төлбөрийн баримт эсхүл экспортод гаргахаар зориулалтын агуулахад хадгалж буй байдал, фото зургаар эсхүл экспортод гаргаж буй аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээ/
07	• Толгой шийр, /худалдах, худалдан авах гэрээ, төлбөрийн баримт бичиг/
08	• Гэдэс дотор, /худалдах, худалдан авах гэрээ, төлбөрийн баримт бичиг эсхүл экспортод гаргахаар зориулалтын агуулахад хадгалж буй байдал, фото зургаар/
09	• Өлөн, /худалдах, худалдан авах гэрээ, төлбөрийн баримт бичиг, экспортод гаргахаар зориулалтын агуулахад хадгалж буй байдал, фото зургаар/
10	• Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний шинжээчийн дүгнэлт, хуулбар, /үнэн/ хувь,
11	• Яс, /худалдах, худалдан авах гэрээ, төлбөрийн баримт бичиг/
12	• Малын гаралтай болон энгийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, төвлөрсөн цэгт дарж булшлах үйл ажиллагаа эрхэлдэг мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулсан байх; /хог хаягдлын гэрээ/
13	• Малын гаралтай болон энгийн хог хаягдлыг ангилан ялгаж хадгалах зориулалтын талбай, байр, сав, бункертэй байх; /фото зургаар/
14	• Бусад

Зураг 10. Бодлогын гэрээ байгуулахад бүрдүүлэх материал (үхрийн түүхий мах)

Эх сурвалж: ХХААХҮЯ, www.mofa.gov.mn


01	• Үйлдвэрийн танилцуулга, /3 хүртэл хуудас/, хүчин чадал /хоноогоор/
02	• Үйлдвэрийн хяналтын камертай эсэх, /үйл ажиллагааг хянах, бичлэг хийх, хадгалах боломжтой/
03	• Мал эмнэлгийн гэрчилгээ, хуулбар /үнэн/ хувь
04	• Дулааны аргаар мах боловсруулах үйлдвэр нь импортлогч оронд бүртгэгдсэн мал төхөөрөх үйлдвэрээс түүхий эд авсан тухай нотлох баримт /гэрээ, төлбөрийн баримт/
05	• Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний шинжээчийн дүгнэлт, хуулбар, /үнэн/ хувь
06	• Яс, /худалдах, худалдан авах гэрээ, төлбөрийн баримт бичиг/
07	• Малын гаралтай болон энгийн хог хаягдлыг ангилан ялгаж хадгалах зориулалтын талбай, байр, сав, бункертэй байх; /фото зургаар/
08	• Малын гаралтай болон энгийн хог хаягдлыг ангилан ялгаж хадгалах зориулалтын талбай, байр, сав, бункертэй байх; /фото зургаар/
09	• Хоёр орны хооронд байгуулсан протоколын дагуу боловсруулж, батлуулсан технологийн заавар;
10	• Бусад

Зураг 11. Бодлогын гэрээ байгуулахад бүрдүүлэх материал (дулааны аргаар боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүн)

Эх сурвалж: ХХААХҮЯ, www.mofa.gov.mn

4.1.4 ТОХИРЛЫН ГЭРЧИЛГЭЭ

Стандарт, Хэмжил Зүйн Газраас экспортлогч нь тохирлын гэрчилгээ авах ба энэхүү гэрчилгээ нь экспортод гаргах бүтээгдэхүүн нь холбогдох стандартуудын дагуу үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн болохыг баталгаажуулна.




Зураг 12. Тохирлын гэрчилгээ авах үйл явц

Эх сурвалж: СХЗГ, www.masm.gov.mn

4.1.5 ГАРАЛ ҮҮСЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Хоёр төрлийн гарал үүслийн нотолгоо, гэрчилгээний талаар энд дурдах шаардлагатай. Эхний ээлжид танай үйлдвэр махаа Монгол Улсын аль аймгаас бүр нарийвчилбал хэн гэдэг малчны хотноос, хоршооноос, мах нядалгааны газраас бэлтгэсэн болохыг харуулах (энэ талаар 4.1.2 болон хавсралт 13-д харуулсан); дараагийн шатанд БНХАУ-д дулааны аргаар боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүн экспортлохоор зөвшөөрөгдсөн бүс нутаг болох Монгол Улсаас гарал үүсэлтэй болохыг баталсан гэрчилгээг авах. Өөрөөр хэлбэл, БНХАУ-д HS 0201, 0202 болон 1602 код бүхий бүтээгдэхүүнийг импортлох шаардлагын дагуу тухайн бүтээгдэхүүн Монгол Улсад үйлдвэрлэгдсэн гэдгийг экспортлогч баталгаажуулах ёстой. Үүний тулд МҮХАҮТ-аас гарал үүслийн гэрчилгээ авна. Дараах зурагт энэхүү гэрчилгээг авахад шаардагдах баримт бичиг, дарааллыг харуулав.



Зураг 13. Гарал үүслийн гэрчилгээ авах үйл явц

Эх сурвалж: МҮХАҮТ, www.mongolchamber.mn

4.1.6 ОЛОН УЛСЫН МАЛ ЭМНЭЛГИЙН ГЭРЧИЛГЭЭ

Экспортлогч нь МЭЕГ-аас мал, амьтны олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ авна. Энэхүү гэрчилгээ нь эрүүл мэнд, мал эмнэлгийн ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан, гарал үүсэл нь тодорхой мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн болохыг баталгаажуулна. Энэхүү гэрчилгээг авахад экспортлогч нь албан хүсэлтийг дараах бичиг баримтын хамт бүрдүүлж, МЭЕГ-т өгнө.


- 01 • Мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний мал эмнэлгийн лабораторийн дүгнэлт, мал эмнэлгийн гэрчилгээ;
- 02 • Хүсэлт гаргагчийн худалдах, худалдан авах гэрээ, бэлэглэлийн гэрээ болон түүнтэй адилтгах баримт бичиг;
- 03 • Хүсэлт гаргагч нь хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, иргэний үнэмлэхний хуулбар;
- 04 • Хүсэлт гаргагч нь мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх, тээврийн хэрэгслийн төрөл, замын чиглэл, нэвтрүүлэх хилийн боомтын нэр, хугацаа;
- 05 • Мал, амьтан , тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо, хэмжээ, боловсруулалтын байдал (хагас боловсруулсан, түүхий, хөлдөөсөн, загсаасан, шинэ гэх мэт) савлалт, шошго, аюулгүй байдлын талаарх мэдээлэл;
- 06 • Боловсруулах үйлдвэрийн дугаар, нэр хаяг, байршил;

Зураг 14. Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ авахад бүрдүүлэх материал

Эх сурвалж: МЭЕГ, www.vet.gov.mn

4.1.7 МАЛ ЭМНЭЛЭГ, АРИУН ЦЭВРИЙН ГЭРЧИЛГЭЭ

Экспортлогч нь МЭЕГ-аас олгосон “Мал, амьтны олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ”-нд үндэслэн МХЕГ-аас Монгол Улсаас БНХАУ-д экспортлох үхрийн мах, дулааны аргаар боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүнд “Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ” (экспортын гэрчилгээ) авна.



Зураг 15. Монгол улсаас БНХАУ-д экспортлох дулааны аргаар боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүнд “Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ” олгох үйл явц

Эх сурвалж: МХЕГ, www.inspection.gov.mn

4.2 ТЭЭВЭРЛЭЛТ

БНХАУ-руу мах, махан бүтээгдэхүүн экспортлогчид нь ихэвчлэн авто замын тээврийг ашиглаж байна. Тээвэрлэлтийг хөргүүртэй, чингэлэгтэй, гаалийн итгэмжлэгдсэн тээврийн хэрэгслээр хийнэ.



Зураг 16. Тээврийн дагалдах бичиг баримт

4.3 ГААЛЬТАЙ ХОЛБООТОЙ ПРОЦЕСС

4.3.1 ЭКСПОРТЫН ГААЛИЙН ПРОЦЕСС

Гаалийн бүрдүүлэлт хийхэд шаардагдах бичиг баримт:

- Гаалийн тухай хуулийн 60-р зүйлд заасан:
 - Гадаад худалдааны гэрээ, эсхүл үнийн нэхэмжлэх;
 - Тээврийн бичиг баримт;
 - Тарифын бус хязгаарлалтад хамаарах бараанд шаардагдах зөвшөөрөл, лиценз;
 - Хууль тогтоомжид тусгайлан заасан бараанд мэргэжлийн хяналтын байгууллагаас олгосон дүгнэлт
- Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 8.2-д заасан:
 - Мэдүүлэгчийн гаргаж өгсөн бичиг баримт нь гаалийн үнийг шалгаж, шийдвэр гаргахад хангалтгүй гэж үзвэл гаалийн байгууллага мэдүүлэгчээс нэмэлт мэдээлэл, бичиг баримт гаргуулан авч болно.



Зураг 17. Гаалийн бүрдүүлэлтийн үе шат

Эх сурвалж: МУ-ын Гаалийн ерөнхий газар, www.customs.mn

Барааг гаальд мэдүүлэх үйл ажиллагаа

Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгслийн талаарх шаардлагатай бүх мэдээллийг гаалийн мэдүүлгийн маягтын дагуу бичиж, холбогдох бичиг баримтын хамт гаалийн байгууллагад өгнө.

Гаалийн мэдүүлгийн маягт, түүний бүтэц (хавсралт 17-аас харна уу):

- Ерөнхий мэдээлэл (1-20 хүснэгт)
- Бараа, тээврийн хэрэгслийн талаарх мэдээлэл (21-43 хүснэгт)
- Гаалийн тариф, татварын мэдээлэл (44-50 хүснэгт)
- Бичиг баримтын мэдээлэл (51 хүснэгт)

Гаалийн хяналт шалгалт

Гаалийн хяналтын төлөв нь улаан, улбар шар, ногоон өнгөөр тодорхойлогдох ба дараах утга санааг илэрхийлнэ. Үүнд:

- Улаан: Биет шалгалт, бичиг баримтын шалгалт хийгдэнэ.
- Шар: Зөвхөн бичиг баримтын шалгалт хийгдэнэ.
- Ногоон: Биет шалгалт, бичиг баримтын шалгалт хийгдэхгүй.

Гаалийн хяналт, шалгалтын төрөл:

- Гаалийн хяналтын бүс дэх хяналт, шалгалт
- Гүний гаалийн хяналт, шалгалт

Барааны ангилал тодорхойлох

Экспортод гаргах бүтээгдэхүүнийг БТКУС-д үндэслэн:

- Экспортод гарахаас өмнө,
- Мэдүүлэх явцад,
- Бүрдүүлэлтийн дараах шатанд тодорхойлж болно.

Гаалийн үнэ, тариф

Экспортын барааны гаалийн үнийг Монгол Улсын “Гаалийн тариф, гаалийн татварын тухай” хуулийн 3.1.4-д үндэслэн тодорхойлно.


Экспортын барааны гаалийн үнэд:

Гэрээ хэлцлийн үнэ + Монгол Улсын хил хүртэл уг барааг хүргэхэд гарах тээврийн зардал + Тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбоотой тээврийн болон экспортын

бичиг баримт, бүрдүүлэлтийн хураамж + Даатгалын шимтгэл + Барааг ачих, буулгах, хадгалах, шилжүүлэн ачихад гарсан зардлууд багтана.

Гаальд бараагаа мэдүүлэх үедээ мэдүүлэгч гаалийн үнийг өөрөө тооцон тодорхойлох, мэдүүлэх журамтай.

4.3.2 ИМПОРТЛОГЧИЙН ГААЛИЙН ПРОЦЕСС



CIQ – China Entry – Exit inspection & Quarantine Bureau / БНХАУ-ын хилийн хяналт, шалгалт хорио цээрийн алба
 CFDA – China Food and Drug Administration / БНХАУ-ын хүнс, эмийн бүтээгдэхүүний удирдах газар
 CNCA – Certificate & Accreditation Administration of China / БНХАУ-ын гэрчилгээжүүлэлт, баталгаажуулалтын газар
 MOA – Ministry of Agriculture / БНХАУ-ын хөдөө, аж ахуйн яам
 MOFCOM – Ministry of Commerce / БНХАУ-ын худалдааны яам
 AQSIQ – Administration of Quality Supervision, Inspection and Quarantine / БНХАУ-ын чанарын хяналт шалгалт, хорио цээрийн ерөнхий газар
 GACC – General Administration of Customs / БНХАУ-ын гаалийн ерөнхий газар

Зураг 18. Импортологчийн бараа хүлээн авах үе шат

БНХАУ-ын импортын барааны татвар, хураамж (GACC, 2019):

- Монгол Улсаас БНХАУ-д экспортлох үхрийн мах (HS: 0201 болон 0202) -ны:
 - Импортын тариф (MFN) 25 хувь,

- Нэмэгдсэн өртгийн татвар (VAT) 9 хувь байна.
- Монгол Улсаас БНХАУ-д экспортлох дулааны аргаар боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүн (HS: 1602) -ий:
 - Импортын тариф (MFN) 5 хувь,
 - Нэмэгдсэн өртгийн татвар (VAT) 13 хувь байна.

4.4 БҮЛГИЙН ШАЛГАХ ХУУДАС

СТРАТЕГИЙН ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХ ЗӨВШӨӨРӨЛ (ХХААХҮЯ)

ДОТООДЫН МАЛ ЭМНЭЛГИЙН ГЭРЧИЛГЭЭ (ОРОН НУТГИЙН МЭГ)

БОДЛОГЫН ГЭРЭЭ (ХХААХҮЯ)

ТОХИРЛЫН ГЭРЧИЛГЭЭ (СХЗГ)

ГАРАЛ ҮҮСЛИЙН ГЭРЧИЛГЭЭ (МҮХАҮТ)

ОЛОН УЛСЫН МАЛ ЭМНЭЛГИЙН ГЭРЧИЛГЭЭ (МЭЕГ)

МАЛ ЭМНЭЛЭГ, АРИУН ЦЭВРИЙН ГЭРЧИЛГЭЭ (МХЕГ)

ТЭЭВРИЙН ДАГАЛДАХ БИЧИГ БАРИМТ

ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТЭД ШААРДАГДАХ БИЧИГ БАРИМТ

ТАВ. БНХАУ-Д ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХ КОМПАНИУДАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орнууд нь улс хоорондын худалдаа арилжааг хязгаарлан боогдуулахгүй байх зорилгоор “Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх хэлэлцээр” (Sanitary and phytosanitary measures- SPS)-ийн хүрээнд харилцан протокол, санамж бичгүүдээр худалдааг хөнгөвчилж байна. Монгол улс БНХАУ-ын хооронд Монгол улсаас БНХАУ-ын зах зээлд үхрийн мах экспортлох үйл ажиллагааг зохицуулах протокол⁷ 2016 онд байгуулсан бөгөөд экспортлогчдын хувьд протоколд тусгасан мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагуудыг зайлшгүй дагаж мөрдөх шаардлагатай юм. БНХАУ-ын Засгийн газраас олон улсын махны нийлүүлэлтийн сүлжээнд тавих хяналтыг чангатгаж хүн ардаа эрүүл хүнсээр хангахад онцгой анхаарч байгаа. Тиймээс мах экспортлогч орон тус бүртэй тусгайлан хэлцэл хийдэг.

Мах экспортлохтой холбоотой анхаарвал зохих дараах нийтлэг бэрхшээлүүд байна. Үүнд:

- БНХАУ-ын Засгийн газрын хэрэгжүүлэгч байгууллагуудын ажил үүргийн давхардал, улс төр, хувь хүмүүсийн харилцаа зэрэг хүчин зүйлс нь хууль журмыг биелүүлэхэд бэрхшээл учруулж төвөгтэй байдал үүсгэдэг
- Экспортлогчдыг шалгах магадлах шалгуур үзүүлэлтүүд болон баталгаажуулалт хийх үе шат нь бүрэн тодорхой бус байдгаас экспортлогчдын хувьд тодорхой бус байдал үүсэх, төөрөгдөх, өөрсдийн дураар шийдэх байдал үүсгэдэг
- Экспортын зөвшөөрөл авахад зардал ихтэй, цаг хугацаа ихээр зарцуулах шаардлагатай байдаг. Жижиг үйлдвэрүүдийн хувьд экспортын зөвшөөрөл авахад шаардагдах хөрөнгө оруулалт болон хүлээгдэж байгаа өгөөжөө сайтар тооцоолох шаардлагатай.
- Экспортлогч болох хүсэлт гаргагч үйлдвэрүүдийн хувьд БНХАУ-ын холбогдох байгууллагуудаас тавигдсан стандартад нийцүүлсэн тоног төхөөрөмжүүдийг суурилуулах, байгаа төхөөрөмжөө тохируулж экспортлогчоор бүртгүүлэх болон БНХАУ-ын талаас ирэх төлөөлөгчид, үйлдвэрийг магадлах шинжээчидтэй холбогдон гарах зардлуудыг төлөлцөх шаардлагатай болдог.
- Экспортлогч болох бүртгэлийн үйл явц ихээхэн хугацаа шаарддаг. Магадлан шалгах шинжээчдийн гаргасан алдаа дутагдлыг засаж залруулах төлөвлөгөөний дагуу ажиллах, дараагийн шинжээч ирж шалгах тохиолдолд дээрх хугацаа тодорхойгүй хугацаагаар сунана.
- Малын төрөл бүрийн өвчинтэй холбоотойгоор зөвшөөрөл олгох үйл явц хэзээ ч тасалдаж болдог.

Мах экспортын тогтвортой байдлыг хангах, мах экспортын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор дараах зөвлөмжүүдийг өгч байна. Эдгээр нь:

1. Мал бэлтгэлийг Монгол Улсын Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг МЭЕГ-аас баталгаажуулсан өвчингүй, эрүүл, тайван бүсээс бэлтгэх, батлах.
2. Мах бэлтгэх зорилгоор бэлтгэж байгаа малын гарал үүслийг батлах: (2018 оноос хэрэгжиж байгаа “Малын гарал үүслийн нэгдсэн систем”-ийг ашиглах)

⁷ “Монгол Улсын МХЕГ болон БНХАУ-ын Чанарын хяналт шалгалт, хорио цээрийн ерөнхий газар хооронд Монгол Улсаас БНХАУ-д экспортлох үхрийн махны хяналт шалгалт, хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн нөхцөлийн тухай протокол (2016.08.29)”

3. Мал нядлах, мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийн бүх процессыг МЭЕГ, МХЕГ-ын эрх бүхий мал эмнэлгийн улсын байцаагч, эсвэл зөвшөөрөлтэй өөрийн үйлдвэрийн эмчийн хяналт доор явуулах бөгөөд хоёр орны протоколд тусгасан шаардлагуудыг дагаж мөрдөх.
4. Зөвхөн үйлдвэрийн аргаар нядалсан малын мах, махан бүтээгдэхүүн экспортлох.
5. Зах зээлийн сегментээ зөв сонгох. Өндөр орлоготой хэрэглэгчдийн сегментэд хүрч ажиллах. БНХАУ-ын зах зээлд өндөр орлоготой хэрэглэгчид (Walmart, Carrefour, CR Vanguard, Suguo, Ole, Sam's club, BHG, Century Mart, RT Mart, Yonghui) зэрэг томоохон сүлжээ супермаркетууд, дээд зэрэглэлийн хайпермаркетуудаар үйлчлүүлж байна. Иймээс эдгээр сүлжээ супермаркетуудтай холбоо тогтоох, импортлогч түнштэйгээ хамтарч ажиллах.
6. БНХАУ-ын хотууд хүн ам ихтэй, амьдралын хэв маяг маш хурдтай завгүй хотууд олон байгаа учраас түргэн шуурхай, тохь тухтай дэлгүүрээр үйлчлүүлэгчдийн тоо маш олон болж байна. Иймээс түргэн шуурхай, тохилог дэлгүүр (Convenience Stores)-ийн сегментэд нэвтрэх. (Suguo Howdy, Carrefour Express, Quick, Kedi/Alldays)
7. Экспортлох бүтээгдэхүүний үнэ цэнийн сүлжээг хөгжүүлэх, аль болох өртөг шингэсэн, боловсруулалт хийгдсэн бүтээгдэхүүн экспортлох. БНХАУ-ын хэрэглэгчдийн амтны таашаал сонирхол өөр учраас хэрэглэгчдийн таашаал, сонирхлыг сайн судлах. Жижиг савлагаатай хатаасан мах, утаж вакуумдасан мах, дотор махан бүтээгдэхүүн, шорлог гэх мэт гүйцэд болон хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортлох.
8. БНХАУ дахь импортлогчтой шууд түншлэл үүсгэхээсээ өмнө хууль зүйн хувьд баталгаатай, улсдаа бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулж ирсэн түүхтэй эсэхийг нь сайн судлах.
9. БНХАУ дахь түнш нь засгийн газрын мэдээлэлтэй ойр, холбоо харилцаатай байвал урьдчилан мэдэгдэхгүйгээр гарах аливаа шийдвэр, шаардлага, бодлогын өөрчлөлтөд бэлэн байх боломж олгоно.
10. БНХАУ-ын аливаа байгууллагын янз бүрийн төвшинд холбоо харилцаатай байх нь тус улсын зах зээлд нэвтрэх болон бусад асуудлуудыг шийдвэрлэхэд маш чухал.
11. БНХАУ-ын хилийн боомтоос хамааран гарах зардал өөрчлөгдөх магадлалтай тул аль болох нэг хилийн боомтоор дагнан экспорт хийх нь цаг хугацаа болон зардал хэмнэхэд тустай.
12. Сав баглаа боодлыг зөв хийх. БНХАУ-ын хүндийн хэмжүүр өөр учраас жин, хатаасан мах, утсан вакуумдсан мах зэргийг бага хэмжээгээр савлах, савлагааны материалыг зөв сонгох, хэрэглэхэд хялбар байхад анхаарах.
13. .
14. Бүтээгдэхүүний маркетингийг өндөр орлоготой хэрэглэгчдэд зориулж Монголын өндөрлөг тал нутгийн экологийн цэвэр бүтээгдэхүүн гэсэн стратегийг баримтлан хэрэгжүүлэх.
15. БНХАУ-ын зах зээлд өөрөө орж ажиллах боломжийг эрэлхийлэх (Одоогоор экспортлогчид БНХАУ-ын импортлогчидтой гэрээ хийн ажиллаж байгаа бөгөөд импортлогч нь БНХАУ-ын гаалийн газраас мах, махан бүтээгдэхүүн импортлох зөвшөөрөлтэй этгээд байхаар зохицуулагдаж байна.)
 - ✓ БНХАУ-ын мах, махан бүтээгдэхүүний зах зээлийн гүнд нэвтрэх боломжийг судлах
 - Хайпермаркетууд (Hypermarket)

- Сүлжээ супермаркетууд (Chain Supermarkets)
 - Мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрүүд (Meat Processing Factories)
 - Онлайн худалдаачид (Online Retailers)
 - Агуулах худалдаа (Warehouse Store)
 - Их дэлгүүрүүд (Department Store)
- ✓ Өөрийн хөрөнгө оруулалттай эсвэл хамтарсан компанийг БНХАУ-д байгуулж импортын зөвшөөрөл авах боломжийг судлах

ЗУРГАА. БНХАУ-Д ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХОД ШААРДЛАГАТАЙ БАРИМТ БИЧИГ

6.1 МОНГОЛЫН ТАЛААС ШААРДЛАГАТАЙ БАРИМТ БИЧГҮҮДИЙН ЖАГСААЛТ

1. Мал эмнэлэг, хорио цээрийн гэрчилгээ, шаардлагатай бичиг баримт (МЭЕГ)
2. Мал, амьтны олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ, шаардлагатай бичиг баримт (МЭЕГ)
3. Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ (экспортын гэрчилгээ), шаардлагатай бичиг баримт (МХЕГ)
4. Гарал үүслийн гэрчилгээ, шаардлагатай бичиг баримт (МҮХАҮТ)
5. Итгэмжлэлийн гэрчилгээ, шаардлагатай бичиг баримт (МХЕГ)
6. Тохирлын гэрчилгээ, шаардлагатай бичиг баримт (СХЗГ)
7. Стратегийн хүнс экспортлох зөвшөөрөл, шаардлагатай бичиг баримт (ХХААХҮЯ)
8. Гаалийн бүрдүүлэлтэд шаардлагатай бичиг баримт (ГЕГ)

6.2 БНХАУ-ЫН ТАЛААС ШААРДЛАГАТАЙ БАРИМТ БИЧГҮҮДИЙН ЖАГСААЛТ

Экспортлогчоор бүртгүүлэхэд шаардлагатай бичиг баримтын жагсаалт:

1. Компанийн талаарх мэдээлэл
2. Өргөдлийн маягт бөглөсөн байх
3. Мах, махан бүтээгдэхүүний дээж, сорил, шинжилгээний тайлан, эрүүл мэнд, ариун цэврийн гэрчилгээ гэх мэт
4. Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ (Экспортын гэрчилгээ)

БНХАУ-ын Гаалийн байгууллагад шаардлагатай бичиг баримтын жагсаалт:

1. Төлбөрийн нэхэмжлэх
2. Сав баглаа боодлын жагсаалт
3. Гарал үүслийн гэрчилгээ (Олон улсын)
4. Стратегийн хүнс экспортлох зөвшөөрөл
5. Мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ (Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ)
6. Ачааны манифест

ДОЛОО. БНХАУ-Д ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХОД ОРОЛЦДОГ БАЙГУУЛЛАГУУД

7.1 Монгол Улс болон БНХАУ-ын талаас оролцогч ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУД

- Монгол Улсын ЗГ, Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот 13381 Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн Газрын IX байр
Утас: 51-262271
Цахим хуудас: <http://mofa.gov.mn/>
- Монгол Улсын Мал Эмнэлгийн Ерөнхий Газар
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот 13381 Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IXа байр
Утас: 51-262482
Цахим хуудас: <http://vet.gov.mn/>
- Монгол Улсын Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар
Хаяг: Засгийн газрын XII байр Барилгачдын талбай-13 Улаанбаатар 15170
Утас: 51-264786
Цахим хуудас: <http://home.inspection.gov.mn/>
- Монгол Улсын Гаалийн Ерөнхий Газар
Хаяг: Монгол Улсын Гаалийн Ерөнхий газар, Сүхбаатар дүүрэг, Их тойруу 81/1 Улаанбаатар-14193
Утас: 11- 350049
Цахим хуудас: <http://customs.gov.mn/>
- Монгол Улсын Стандарт Хэмжил Зүйн Газар
Хаяг: Энхтайваны өргөн чөлөө 46А Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот. 13343
Утас: 458349
Цахим хуудас: <https://masm.gov.mn/>
- Нийслэлийн Мал Эмнэлгийн Газар
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2 р хороо, Чингүүнжавын гудамж, Нийслэлийн мал эмнэлгийн газрын байр.
Утас: 70144009, 70144007
Цахим хуудас: <http://vet.ub.gov.mn/>
- БНХАУ-ын Гаалийн Ерөнхий Газар (GACC)
Хаяг: No. 6 Jianguomennei Avenue, Dongcheng District, Beijing, China
Шуудангийн код: 100730
Утас: 010-65194114
Цахим хуудас: <http://nhfpc.gov.cn> , <http://en.nhfpc.gov.cn>
- БНХАУ-ын Зах Зээлийн Удирдлага, Зохицуулалтын газар (SAMR)
Хаяг: No. 8 Sanlihe East Road, Xicheng District, Beijing, China
Шуудангийн код: 100820
Утас: 010-88650000
Цахим хуудас: <http://www.samr.gov.cn/>
- БНХАУ-ын Эрүүл Мэндийн Үндэсний Комисс (NHCC)
Хаяг: No. 1 Xizhimen Outer South Road, Xicheng District, Beijing, China
Шуудангийн код: 100044
Утас: 010- 68792114
Цахим хуудас: <http://www.nhc.gov.cn/>, <http://en.nhc.gov.cn/>
- БНХАУ-ын Баталгаажуулалт, Итгэмжлэлийн Газар (CNCA)
Хаяг: No. 9 Madian East Road, Haidian District, Beijing, China

Шуудангийн код: 100088

Утас:010-58116300

Цахим хуудас: <http://www.cnca.gov.cn/>

- БНХАУ-ын Стандартын Удирдлагын Газар (SAC)
Хаяг: No. 9 Madian Doglu, Haidian District, Beijing, China
Шуудангийн код: 100088
Утас:010-82262609
Цахим хуудас: <http://www.sac.gov.cn/>

7.2 Монгол Улс болон БНХАУ-ын талаас оролцогч ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУД


- Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим
Хаяг: Улаанбаатар хот, 17011, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Махатма Гандигийн гудамж, МҮХАҮТ-ын байр.
Утас: 77277070
Цахим хуудас: <https://www.mongolchamber.mn/>
И-мэйл: info@mongolchamber.mn
- Монголын Махны Холбоо
Утас: 99113938
- Монголын Экспортлогчдын Холбоо
Утас: 99119356
Цахим хуудас: <https://vip76.mn/organization/173>
- БНХАУ-ын All-China Federation of Industry and Commerce (ACFIC)
Хаяг: No.70, West Deshengmen Street, Xicheng District, Beijing, China
Шуудангийн код: 100035
Утас: 0086-10-58050500
Цахим хуудас: <http://www.chinachamber.org.cn/>

7.3 Монгол Улсын Гаалийн Ерөнхий Газраас итгэмжлэгдсэн ТЭЭВРИЙН КОМПАНИУД


Экспортын тээвэрт гаалийн итгэмжлэгдсэн тээврийг ашиглах бөгөөд 2019.11.18-ны байдлаар нийт 190 тээврийн компани ГЕГ-т бүртгэлтэй байгаа бөгөөд эдгээр компаниас мах, махан бүтээгдэхүүн тээвэрлэх зориулалтын тээврийн хэрэгсэлтэй компанийг сонгон үйлчлүүлээрэй. Дараах холбоосыг ашиглан гаалийн итгэмжлэгдсэн тээврийн зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн мэдээллийг авна уу (www.customs.gov.mn/images/publishers/GIT_jagsaalt_2019.11.18.pdf).

НАЙМ. БНХАУ-ЫН ЗАХ ЗЭЭЛД ХИЙХ ҮХРИЙН МАХНЫ ЭКСПОРТЫН ПРОГНОЗ

Олон улсын худалдааны байгууллага (ОУХБ) болон МУ-ын ГЕГ-ын статистик мэдээ, мөн үхрийн махны экспортод нөлөөлөх гол хүчин зүйлсийн өнөөгийн төлөв байдал, цаашдын хандлагыг харгалзан үзэж, БНХАУ-д экспортлох үхрийн махны цаашдын хандлагыг тодорхойлон дараахь зургаар харууллаа.



Зураг 19. Монгол Улсын үхрийн тоо болон үхрийн махны дотоодын үйлдвэрлэлийн хандлага
Эх сурвалж: Монгол Улсын ҮСХ, ГЕГ болон бусад судалгааны тайланд үндэслэн өөрсдийн тооцсон үр дүн



Зураг 20. Монгол Улсаас БНХАУ-руу экспортлох дулааны аргаар боловсруулсан үхрийн мах, махан бүтээгдэхүүний хандлага

Эх сурвалж: Монгол Улсын ҮСХ, ГЕГ болон бусад судалгааны тайланд үндэслэн өөрсдийн тооцсон үр дүн

ЕС. ХАВСРАЛТ / ЦАХИМ ХУУДАСНЫ ЛИНК

Хавсралтаар харуулсан мэдээллийг www.inrae.mn/appendix цахим холбоосыг ашиглан дэлгэрэнгүй үзнэ үү.

- ХАВСРАЛТ 1. ISO СТАНДАРТЫН ГЭРЧИЛГЭЭ
- ХАВСРАЛТ 2. НАССР-ИЙН ГЭРЧИЛГЭЭ
- ХАВСРАЛТ 3. “MNS SAC GAL 24:2014” СТАНДАРТЫН ГЭРЧИЛГЭЭ
- ХАВСРАЛТ 4. МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ИТГЭМЖЛЭЛ
- ХАВСРАЛТ 5. БНХАУ-Д ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХРИЙН МАХ, ҮХРИЙН МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХ МАХ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН БНХАУ-ЫН “ЗАСГИЙН ГАЗРЫН БАТАЛГААЖУУЛАЛТ, ИТГЭМЖЛЭЛИЙН ГАЗАР”-ААР ХЯНАН МАГАДАЛГАА ХИЙЛГЭХ ӨРГӨДЛИЙН МАЯГТ, БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ ТАЙЛБАР
- ХАВСРАЛТ 6. БНХАУ-ЫН ИМПОРТЫН ЗӨВШӨӨРӨЛ
- ХАВСРАЛТ 7. ГАДААДАД БАРАА БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР
- ХАВСРАЛТ 8. АЧАА БАРАА ТЭЭВЭРЛҮҮЛЭХ, ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ
- ХАВСРАЛТ 9. ДОТООДЫН МАЛ ЭМНЭЛГИЙН ГЭРЧИЛГЭЭ
- ХАВСРАЛТ 10. БОДЛОГЫН ГЭРЭЭ
- ХАВСРАЛТ 11. ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН
- ХАВСРАЛТ 12. МАЛ ЭМНЭЛГИЙН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН
- ХАВСРАЛТ 13. ХАРИУЦЛАГАТАЙ НҮҮДЭЛЧИД БАР КОД АВАХ
- ХАВСРАЛТ 14. ОЛОН УЛСЫН МАЛ ЭМНЭЛГИЙН ГЭРЧИЛГЭЭ
- ХАВСРАЛТ 15. ТЭЭВЭРЛЭГЧ БАЙГУУЛЛАГАД ГААЛИЙН ИТГЭМЖЛЭЛ ОЛГОХ ШАЛГУУР
- ХАВСРАЛТ 16. АМЬТАН, УРГАМАЛ, БОДИС, БАРАА, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТАД ХАМРУУЛСАН ТУХАЙ МЭДЭГДЭЛ
- ХАВСРАЛТ 17. ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТИЙН МАЯГТ, ЗААВАР
- ХАВСРАЛТ 18. ГААЛИЙН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ БАРААНЫ МЭДҮҮЛГИЙН МАЯГТ
- ХАВСРАЛТ 19. БНХАУ-РУУ МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТЛОХ ХИЛИЙН БООМТУУД
- ХАВСРАЛТ 20. МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗАР БОЛОН БНХАУ-ЫН ЧАНАРЫН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ, ХОРИО ЦЭЭРИЙН ГАЗАР ХООРОНД МОНГОЛ УЛСААС БНХАУ-Д ЭКСПОРТЛОХ ҮХРИЙН МАХНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ХОРИО ЦЭЭР, МАЛ ЭМНЭЛЭГ, АРИУН ЦЭВРИЙН НӨХЦӨЛИЙН ТУХАЙ ПРОТОКОЛ
- ХАВСРАЛТ 21. МОНГОЛ УЛС БОЛОН БНХАУ-ЫН ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУДЫН ХООРОНД БАЙГУУЛСАН ҮХРИЙН МАХ БОЛОН ДУЛААНЫ АРГААР БОЛОВСРУУЛСАН ҮХЭР, ХОНЬ,
- ХАВСРАЛТ 22. ЧАНАЖ БОЛОВСРУУЛСАН МАХ, ТЕХНИКИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА (MNS 6790:2019)